

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 44
1. <i>Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх</i>	7
2. <i>Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох</i>	8 – 41
3. <i>Засгийн газрын гишүүн тангараг өргөнө</i>	41 – 44

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 51 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Х.Ганхуяг, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Ч.Номин, Г.Очирбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Б.Түвшин, Д.Цогтбаатар, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Баярбаатар, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара, Г.Хосбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Д.Пүрэвдаваа, М.Сарнай, Б.Тулга, Д.Энхтүвшин;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Н.Алтаншагай, Х.Баттулга, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Т.Доржханд, Б.Жавхлан, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Л.Оюун-Эрдэнэ, П.Сайнзориг, Х.Тэмүүжин;

Хоцорсон: Т.Аубакир – 07 минут, Д.Батбаяр – 15 минут, Ж.Батсуурь – 03 минут, Э.Болормаа – 03 минут, Д.Бум-Очир – 08 минут, А.Ганбаатар – 03 минут, Б.Жаргалан – 01 цаг 32 минут, С.Зулпхар – 01 минут, Б.Найдалаа – 02 минут, О.Номинчимэг – 02 минут, Э.Одбаяр – 42 минут, Д.Рэгдэл – 01 минут, О.Саранчулуун – 15 минут, Р.Сэддорж – 05 минут, Ч.Ундрэм – 19 минут, М.Энхцэцэг – 50 минут.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанаар мэдээлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсаныг танилцуулав.

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн

байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнийг танилцуулав.

Н.Учрал: Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 25
Бүгд: 72
65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Ж.Энхбаяр, М.Бадамсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг чөлөөлөх, томилох саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, С.Одонтуяа, Ц.Мөнхбат, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн, П.Мөнхтулга, О.Амгаланбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Ж.Энхбаяр, М.Бадамсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

Чуулганы нэгдсэн хуралдааныг Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангуулахаар 17 цаг 23 минутаас 17 цаг 46 минутад түр завсарлуулав.

Гурав.Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагаа

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Ж.Энхбаяр, М.Бадамсүрэн нар оролцов.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, референт Д.Батжаргал, шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэн байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Засгийн газрын гишүүний нэрийг дуудав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын

гишүүн-Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн сайд М.Бадамсүрэн нар Монгол Улсын Төрийн сүлд рүү харан зогсож, тангарагийг уншив.

Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүд Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Засгийн газрын гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулсны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Н.Учрал шинээр томилогдсон Засгийн газрын гишүүдэд баяр хүргэв.

Уг асуудлыг 17 цаг 54 минутад хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн референт Б.Нарантуяа, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 81 гишүүн ирж, 64.2 хувийн ирцтэйгээр 17 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
15 цаг 51 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 3 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хуулийн төсөл Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Гуравдугаарт, Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанаар мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар Та бүхэнд танилцуулъя.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг 11 дүгээр сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг өнөөдөр Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан байгаа.

Ингээд эхний асуудлаар энэ хуулийн төслийн яаралтай эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг
яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх**

Их Хурлын чуулганаар Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан байдаг Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасан.

Энэ дагуу 11 сарын 25-ны өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн тус хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулаад Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар эхлээд санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Бүртгэлийн санал хураалт.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

47 гишүүн зөвшөөрч, 25 гишүүн татгалзсан байна.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжлээ. /алх цохив/

Төслийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлье. Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай
Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох**

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар таныг индэрт урья.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилох шийдвэрээ танилцуулж байна.

Энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчид 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 130 тоот албан бичгээр танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилох Жадамбын Энхбаярын дэлгэрэнгүй намтрыг Монгол Улсын Их Хуралд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 133 тоот албан бичгээр хүргүүлж гишүүдэд тараасан болно.

Жадамбын Энхбаяр нь хуульч мэргэжилтэй. Улсад 31 жил ажилласан. Улсын Их Хурлын гишүүнээр 4 удаа сонгогдсон. 2024 оноос Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар ажиллаж байна.

Жадамбын Энхбаяр нь мэргэжлийн хяналт, хөдөө аж ахуй, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлын салбарт бодит үр дүн гаргаж ажилласан ажлын туршлагатай.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд өсөж байгаа хэдий ч эдийн засгийн суурь бүтэц сул, нэг салбараас хэт хамааралтай, эдийн засаг төрөлжөөгүй, солонгороогүй байна.

Өнөөдөр манай экспортын 90 гаруй хувь нь уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай нь эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн бас нэг гол эрсдэл болж байгаа.

Ийм учраас орчин үеийн эдийн засгийн болон геополитикийн өөрчлөлт Монгол Улсын эдийн засгийн хөгжил тогтвортой байдалд нөлөөлж байгааг харгалзсан. Энэ нь бас иргэдийн өрхийн орлого, төсөв, амьжиргаанд хүчтэй нөлөөлж байна.

Ийм учраас төсвийн сахилга бат, өрийн удирдлага, бүтцийн шинэчлэл, дунд болон урт хугацааны төлөвлөлт сул байсан нь эдийн засгийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулж ирсэн.

Ийм учраас эдийн засгийг төрөлжүүлэх, солонгоруулах, эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, хөгжлийн бодлогын уялдаа холбоог нэг мөр зангидах, үр дүнд суурилсан эдийн засгийн тогтолцооны шинэ үе рүү шилжилт хийх, эдийн засгийн бүтцэд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатайг цаг үе бидэнд сануулж байгаа.

Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжсэн бизнесийн орчны дарамтыг арилгасан. Нэг талаасаа бизнес эрхлэгчид, аж ахуй эрхлэгчидэд дарамт чирэгдэл багатай хяналтын тогтолцоо, нөгөө талаасаа иргэдийн эрүүл аюулгүй байдал, амьдрах орчныг хангахын тулд ил тод, эрсдэлд суурилсан, хариуцлагатай төрийн хяналтын шинэ тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ийм учраас энэ асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүнээр Жадамбын Энхбаяр ажлын туршлага, онцлог, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсан болон мэргэжлийн хяналтын салбарт ажиллаж байсан туршлагыг харгалзан үзэж Тэргүүн Шадар сайдын албан тушаалд Жадамбын Энхбаярыг томилж байгаа юм.

Энэ бол зөвхөн Засгийн газрын асуудал бус Монгол Улсын ирээдүйн хөгжил, өрх бүрийн амьдралын чанар, эдийн засгийн тусгаар тогтнолыг хангахад зайлшгүй шинэчлэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай туршлага, мэдлэгийг нь харгалзан үзлээ.

Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн сайдад нэр дэвшүүлж байгаа Жадамбын Энхбаяр нь энэхүү өндөр хариуцлагыг биелүүлэх мэдлэг, туршлага, бодлогын манлайлал, ажлын туршлагатай гэж харгалзан үзэж энэ албан тушаалд томилж байна.

Улсын хөгжлийн суурь бодлогыг нэгтгэх, эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, бүтцийн реформыг тууштай хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, дундаж давхаргыг тэлэх бодлогыг удирдан чиглүүлэх бүрэн чадамжтай гэж үзэж энэхүү шийдвэрийг Та бүхэнд танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Энэ чинь чөлөөлөхийг уншихгүй билүү? Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх. Тийм үү. Танилцуулсан уу?

Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох саналаа танилцуулна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Ерөнхий сайд онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Жадамбын Энхбаярыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас чөлөөлөх, Тэргүүн Шадар сайдаар томилох саналыг танилцууллаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын даргаар томилогдсон Ням-Осорын Учралыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Тэргүүн Шадар сайдын албан тушаалаас чөлөөлөх саналыг танилцуулж байна.

Энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдыг чөлөөлсөнтэй холбогдуулан Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар томилох шийдвэрээ танилцуулж байна.

Энэ томилгооны асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчид 11 дүгээр сарын 24-ний өдрийн 131 тоотойр албан бичгээр танилцуулсан болно.

Жадамбын Энхбаярыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103.1 дэх хэсгийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх, түүнчлэн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг сайдаар томилох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж байна.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэнгийн дэлгэрэнгүй намтрыг Монгол Улсын Их Хуралд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 134 тоот албан бичгээр танилцуулсан болно.

М.Бадамсүрэн нь Төрийн удирдлагын менежер мэргэжилтэй. Инженер. Улсад 18 жил ажилласан. 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.

Эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт нэн чухал зорилтууд хүлээгдэж байна.

Энэ бол эрчимжсэн хөдөө аж ахуйн төрөлжсөн дэд бүсүүдийг бий болгож, экспортыг нэмэгдүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүргийг бий болгох, орон нутгийн хөгжлийн төвүүдэд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдаа логиستيкийн кластер төвүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийг олон улсын стандартад шилжүүлж, олон улсын стандартыг Монгол Улсад нутагшуулах, сүү, мах, ноолуур, арьс шир зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортыг тэлэх, хүнсний хувьсгал, цагаан алт зэрэг томоохон хөтөлбөрүүдийг үр дүнтэй, бүтээлчээр хэрэгжүүлэх зэрэг стратегийн чухал ач холбогдлууд шинэ таван жилийн төлөвлөгөөнд зорилтууд болон тусгагдсан.

Эдгээр ажлыг бодитой хэрэгжүүлэхийн тулд салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд, урт хугацаанд оновчтой уялдаатай инновац, технологи, кластерт суурилсан шинэ бүтцээр удирдах шаардлага тулгарч байна.

Ийм эгзэгтэй цаг үед улс төрийн зорилтоо амжилттай хэрэгжүүлж, улсын эрх ашгийг дээгүүр тавьж, хүлээсэн ажлаа хариуцлагатайгаар гүйцэтгэх нь салбарын зайлшгүй чухал зорилт болж байна.

Иймд Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг салбарын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж, тулгамдсан асуудлуудад бодит шийдэл гаргах ур чадвар, хөдөө орон нутагт олон жил удирдан зохион байгуулах туршлага, ажил хэрэгч чанарыг нь харгалзан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан тушаалд нэр дэвшүүлэн танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Монгол Улсын Ерөнхий сайдад баярлалаа.

Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Их Хуралд танилцууллаа.

Танилцуулгатай холбогдуулаад Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. О.Амгаланбаатар гишүүнээр тасаллаа.

О.Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Жадамбаагийн Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилж байгаа юм байна. Монгол Улсын Ерөнхий сайд.

Ер нь харамсалтай байна. Үндсэндээ хамтарсан Засгийн газрын үйл ажиллагаанаас хойш дараа нь Засгийн газар байгуулагдаад өдийг хүртэл Монголын хөдөө аж ахуйн бодлого маш тууштай маш сайн явсан юм.

Өнөөдөр малчид мах үнэтэй байгаад баярлаж байна. Малчдын мах гэв гэнэт үнэлгээнд ороогүй л дээ. Гадагшаагаа гаргадаг элдэв квот, хориг саад өнгөрсөн жил гаруй хугацаанд эрс багассан.

Монгол Улс анх удаагаа 1990 оноос хойш түүхий ноолуураа экспортлолгүй 2025 онд бүх ноолуураа дотоодын үйлдвэрүүд нь аваад самнаад боловсруулаад явж байна.

Энэ бол Монголын хөдөө аж ахуйн салбарт гарсан маш том амжилт.

Өнөөдөр мал байхгүй бол малчин байхгүй. Малчин байхгүй бол Монгол байхгүй.

Үнэхээр малчид руу чиглэсэн бодлого, хөдөө аж ахуйн салбарын бодлого үнэхээр сайн явсан. Энэ бодлогыг гол зангидаж явсан, яамаа хүртэл Дархан руу нүүлгээд тэндээ үр дүн гаргасан Ж.Энхбаяр сайдыг Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилж байгаад харамсаж байна.

Тэгэхдээ нэгэнт Монгол Улсын Ерөнхий сайд өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргаж байгаа учраас энэ дээр юу хэлэх вэ. Харин томилогдож байгаа М.Бадамсүрэн сайд энэ асуудлыг сайн анхаарч ажиллах нь зүйтэй.

Нэн ялангуяа хавар болоод л мах жоохон үнэтэй болох гээд ирэнгүүт хүчээр нөөцийн мах гэж баахан бэлдээд л мах хямдруулж зараад л инфляц өслөө гээд хүчээр малчдын амьжиргаа руу халддаг олон жил үргэлжилсэн энэ нэг муухай юмыг болиулаарай.

Үндсэндээ малчдын ганц амьжиргаа болох мал, махных нь үнэ дээр хязгаарлалт тогтоочоод төр өөрийнхөө нөөцөөр хямдхан авч бэлдэж тараачхаад тэгээд амьдрал ахуй нь тааруухан байгаагийн төлөө эргээд Улсын Их Хурлын чуулган, олон газраас малчдаа буруутгаад суудаг хачин хандлага гарсан шүү.

Малчдын мах нь үнэтэй, түүхий эд нь бүтээгдэхүүн болж гараад байх юм бол малчид төр засгаас юу ч гуйхгүй. Гуйдаг ч үгүй. Өөрсдийнхөө амьдралыг аваад явчихна.

Түүхий эдийнх нь үйлдвэрийг бариулахгүй, махных нь үнийг хязгаарлана. Тэгээд дээрээс нь элдвээр малчдаа хэлээд суугаад байвал бид удахгүй малчингүй болоход их ойрхон байгаа шүү.

Энэ дээр шинээр томилогдож байгаа Хөдөө аж ахуйн сайд маш анхааралтай ажиллаарай.

“Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд маш олон үйлдвэрүүд шинээр нээгдсэн. 50 гаруй үйлдвэр шинээр нээгдсэн гэсэн статистик байгаа. Мянга гаруй малын гаралтай бараа, бүтээгдэхүүн хийж байгаа гэсэн статистик байгаа. Үхрийн шир хаягдахаа больсон. Хонины нэхий дээр жоохон асуудал байгаа гээд.

Өнгөрсөн жил гаруйн хугацаанд гарсан амжилтыг үргэлжлүүлээрэй. Зөвхөн чуулганы индэр, зурагтын дэлгэц, элдэв юман дээр малчдадаа хайртай биш бодит амьдрал дээр малчдыгаа дэмжсэн, малын түүхий эд, мал, махыг өөрийн үнэ цэнтэй зах зээлийнх нь жамаар байлгахыг чиглэсэн бодлогыг авч хэрэгжүүлээрэй.

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар Монгол Улсын уламжлалт тэргүүлэх салбар.

Харамсалтай нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас нь авхуулаад салбарыг нь олон тийшээ тараагаад салгасан, олон удирдлагуудтай болчихсон юм билээ.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын дарга нь хүрээлэнгийнхээ захирлыг дуудаад уулзаж чадахаа больсон юм билээ. Иймэрхүү алдаа завхралуудыг цаашид анхаарч засаарай.

Хамгийн гол нь өдийг хүртэл явсан өнгөрсөн жил гаруй хугацааны хөдөө аж ахуйн салбарын зөв зүйтэй бодлогыг үргэлжлүүлээрэй гэж захъя. Асуулт алга. Баярлалаа.

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: О.Алтангэрэл гишүүний саналтай зарчмын хувьд санал нэг байгаа учраас Жадамбын Энхбаяр сайдыг Эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан Тэргүүн Шадар сайдаар томилж байгаа.

Яагаад гэвэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар хамгийн олон ажлын байр бий болгож, нэмүү өртөг шингээж байгаа салбар.

2022 онд бид Улсын Их Хурлаас түүхий ноолуурыг экспортлохыг хориглосон шийдвэр гаргаж, нэмүү өртөг шингээж, эмэгтэй ажлын байр олноор бий болгодог хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжих тогтоол баталсан.

Энэ дагуу ноолуурын салбарт нэг шат ахисан “НЭГ ШАТ” гэдэг бодлого явуулаад шат ахиж, түүхий ноолуур биш самнасан ноолуур гаргаснаар энэ жил зөвхөн самнасан ноолуурын экспорт 247.0 сая долларт хүрсэн.

Бид түүхийгээрээ 320 орчим сая долларын ноолуур экспортолдог байсан бол одоо самнасан болон нэмүү өртөг шингээсэн 400 гаруй сая долларын ноолууран бүтээгдэхүүн экспортолж байна.

Цаашдаа энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Эдийн засгийн яам бол эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, тухайлах юм бол Евроазийн 183 сая хүнтэй, 2 триллион долларын зах зээлийн 11 тэрбум долларын ноос, ноолууран бүтээгдэхүүн, мах, арьс ширэн бүтээгдэхүүн худалдаж авдаг энэ зах зээл рүү нэвтрэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яам чөлөөт худалдааны хэлэлцээрт эдийн засгийн бодлогыг хариуцдаг учраас томилж байгаа гэж ойлговол зохино.

Ийм ч учраас манай газар тариалан, хөдөө аж ахуйн салбар хоцрогдох шинжтэй явж ирснийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгож хөгжүүлэх зорилт дэвшүүлж байгаа.

М.Бадамсүрэн гишүүн нэн ялангуяа эрчимжсэн мал аж ахуй түлхүү хөгжиж байгаа зүүн бүс Дорнод аймгаас сонгогдсон гишүүн бөгөөд манай мал аж ахуйг эрчимжүүлэх, цаашдаа модернизац хийх, хөдөө орон нутгийн аж амьдралыг сайтар мэддэг гишүүний хувьд хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуйн салбарыг, таны хэлж байгаа мал, махны салбарыг хөгжүүлэхэд өөрийн санаачилга, бодлого, хөтөлбөр дэвшүүлж ажиллаж байгаа учраас энэ чиглэлээр томилж байгаа.

Мэдээж “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” гээд таны хэлж байгаа бүх хөтөлбөрүүд хэрэгжинэ.

Махны экспорт манайх нэмэгдсэн. Одоо энэ жил гэхэд бид ноднингийнхоо экспортыг даблдах, нэмэгдүүлэх зорилт тавиад ажиллаж байна. Ингэснээрээ бид нүүрс, уул уурхайн бүтээгдэхүүнээс гадна хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлогч улс болгохыг зорьж байгаа.

Энэ хүрээнд М.Бадамсүрэн гишүүн “Цагаан алт”, энэ хөтөлбөрүүдийг мэдээж Засгийн газрын тогтвортой бодлогыг үргэлжлүүлэх бөгөөд харин мал аж ахуйд модернизац хийх, хөдөөгийн амьдралын туршлагыг сайн мэддэг учраас хэрэгжүүлж байгаа.

Одоо жишээлбэл шууд малчдын захыг нээснээрээ махны үнэ харьцангуй хямдарсан.

Ер нь таны хэлж байгаагаар яг малчдад өгөөж нь очдоггүй, ченжүүдийн гар дамжаад, хотод хэдийгээр үнэтэй зарагдаад байвч яг малчдын гар дээр очдог мөнгө нь хоёр дахин бага байдаг.

Ийм учраас... /минут дуусав/

Н.Учрал: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: М.Бадамсүрэн нэр дэвшигчээс ганц л асуулт асууя.

“Шинэ хоршоо” хөтөлбөр нийт 860.0 тэрбум төгрөгийн зээл гарсан. Үүнээс ердөө 4.6 хувийн эргэн төлөлттэй гэж байгаа.

Энэ асуудлыг Та орон нутагт ажиллаж байх үедээ нэлээд судалсан байх. Энэ дээр ер нь ямар арга хэмжээ авахаар байна? Энэ талаар бодож байгаа зүйл байна уу?

Үлдсэнийг нь Ж.Энхбаяр нэр дэвшигчээс асууя. Хувийн хэвшил, ЖДҮ-г хэрхэн дэмжих вэ? Сая манай бүлэг дээр ирсэн мэдээллээр хувийн хэвшил нийт 6.5 их наядын өртэй байна гэж.

Энэ их өртэй байгаа хувийн хэвшлээ хэрхэн дэмжих юм? Өрөөс хэрхэн гаргах вэ? Ер нь ажиллах хүчний 90 хувь чинь бараг жижиг, дунд үйлдвэр эзэлж байгаа шүү дээ. Энэ дээр асуулт асуумаар байна.

Гурав дахь асуулт нь бас Ж.Энхбаяр сайдаас. Өмнөх Засгийн газрын мэдээлэл дээр Э.Батшугар сайд хэлсэн. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний ердөө 0.12 хувийг цахим эдийн засаг эзэлж байна гэж.

Тэгэхээр цахим эдийн засгийн талаар Та ямар арга хэмжээ авъя, энэ чиглэлийг хэрхэн хөгжүүлж гэж бодож байна? Эсвэл нөгөө уламжлалттайгаа зууралдаад байх юм уу? Хамгийн гол юм чинь бид ертөнцийн мухарт байгаа улс биш шүү дээ. Манай хөрш Хятад Улсын цахим эдийн засгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 45 хувийг давсан.

Тэгэхээр энэ талаар бид хэт их хоцрогдож байна. 0.12 гэж. Энэ бол өөрөө авлигыг бууруулах хамгийн чухал хэрэгсэл байгаа.

Тэгэхээр энэ асуудал дээр тооноос чанарт шилжүүлэх, өөрөөр хэлбэл уламжлалт аргаа мэдээж хэрэглэнэ. Уламжлалт эдийн засаг. Нүүрсээ экспортлох бусад аргууд явна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн. Бүр том уламжлалт бус чанарын өөр түвшинд гаргах зоригтой реформыг та эхлүүлж чадах уу? Ийм гурван асуулт байна.

Н.Учрал: Нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: “Шинэ хоршоо” хөдөлгөөн 2023-2024 оны зудтай жил зудын эрсдэлийг багасгах зорилгоор анх санаачилж хэрэгжиж эхэлсэн гэж ойлгож байгаа.

“Шинэ хоршоо” хөдөлгөөний талаар сая улсын төсөв хэлэлцэх явцад олон гишүүд саналаа илэрхийлсэн.

Тийм учраас санхүүжилтийн хувьд эрс буурсан байгаа. Ер нь цаашдаа “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг илүү дундын хоршоо хэлбэрээр, илүү тийм

логистикийн төв хэлбэрээр хөгжүүлэхэд зориулж энэ дээр хөрөнгө оруулалт, дэмжлэгүүдийг оруулах нь оновчтой юм уу гэсэн саналыг мэргэжлийн байгууллагууд гаргадаг. Тухайлбал, түүхий эд бэлтгэлийн тогтолцооны хувьд илүү анхан шатын ангилал хийх, хоршоод малчдаас илүү төвлөрүүлж боловсруулах үйлдвэртээ бэлдэх шаардлага зүй ёсоор урган гарч байгаа.

Ингэхгүй болохоор боловсруулах үйлдвэрүүдтэй бэлтгэж байгаа арьс шир, бусад түүхий эд гээд энэ зүйлүүд маань тийм шаардлага хангахгүй. Өөрөөр хэлбэл илүү тээврийн зардал гаргах гэдэг юм уу, ийм зүйл рүү орж байгаа.

Эхний ээлжид үржлийн мал худалдан авч өсгөж үржүүлэх гэдэг энэ чиглэлд өгсөн зээлийг нь өнгөрсөн оноос эхлээд зогсоосон юм билээ.

Тэгэхээр цаашдаа илүү шүүмжлэл, санал, зөвлөмж дээр үндэслээд энэ “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг зөвлөн туслах үйлчилгээтэй буюу яг бизнес эрхлэгч гэдэг энэ статусаар нь явуулах, цаашдаа малчдыг хоршоог малын тооноос гадна ямар хэмжээний ашиг, орлого олсон бэ гэдгээр нь илүү дэмжиж урамшуулах, эдийн засгийн эргэлтийг нь сайжруулах чиглэл рүү “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг илүү о боловсронгуй болгож сайжруулах, шинэчлэх талаар анхаарч ажиллая гэж одоогоор ингэж бодож байна. Баярлалаа.

Н.Учрал: Жадамбаагийн Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Цахим эдийн засгийн асуудлыг Та хөндлөө.

Үнэхээр Монгол Улсын дотоодын бүтээгдэхүүнд цахим эдийн засгийн эзлэх хувь хэмжээ 0.12. Туйлын чамлалттай.

XXI зуун өөрөө цахим технологи, хагас дамжуулагчийн зуун. Хагас дамжуулах буюу цахим технологи дэлхийн геостратегийг тодорхойлно. Дэлхийн их гүрнүүд энэ зах зээлд ноёрхохын төлөө тэмцэл өрнөж байгаа.

XX зуунд газрын тосны төлөө явсан шиг XXI зуун хагас дамжуулагч.

Шинэ цахим эдийн засгийг Монгол Улс бий болгох. Энэ бол Монгол Улсын стратегийн нэг номерын зорилт байх ёстой. Яагаад гэвэл бид хоёр их гүрэн, хуурай газрын түгжигдсэн эдийн засаг, гарцын хувьд туйлын өрсөлдөх чадвар сул. Харьцангуй уламжлалт түүхий эдийн экспорт дээр тулгуурлаж байгаа Монгол Улсын эдийн засгийг... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Энхбаяр гишүүнд 1 минут өгье.

Ж.Энхбаяр: Монгол Улсын эдийн засгийг шинэ түвшинд гаргах гол бодлого бол цахим эдийн засгийг бид бий болгох, хөгжүүлэх бүхий л таатай орчныг бүрдүүлэх чиглэл дээр ажиллах ёстой. Тэгж байж Монгол Улс дэлхийн энэ 8 тэрбум зах зээл рүү гарна.

Энэ бодлогыг хэрэгжүүлэх нь Монгол Улсыг хөгжүүлэх хөгжлийн үндсэн цөм бодлого байх болов уу гэж бодож байна. Үүнийгээ хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарын “Шинэ итгэл, эрс шинэтгэл” гэсэн томоохон эдийн засгийг хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ дотор энэ бодлого нэлээн бодитой байр суурь эзэлж байгаа. Үүнийг хэрэгжүүлэх нь онцгой чухал.

Нөгөө талаар жижиг, дунд үйлдвэрлэл. Нийт Монгол Улсад байгаа аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь жижиг, дунд үйлдвэрлэгчид байгаа. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд бид бизнесийг либералчлах, бизнестсийг... /минут дуусав/

Н.Учрал: Ахиад 1 минут өгье. Ж.Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Ер нь эдийн засгийг сууриар нь сайжруулаад хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх онцгой чухал байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын түвшин олигтой ахиж чадахгүй буугаад байгаа байдал байна. Бид бизнес үйл ажиллагаа саадгүй явуулах, өмчийн халдашгүй байдлыг хангах бодлого хэрэгжүүлэх цаг болсон. Өмч эмзэг байгаа. Хувийн өмчийг хамгаалах, бизнесийг дэмжих бодлогыг бид явуулж байж. Нөгөө талаар төрийн байгууллагуудын хариуцлага хяналтын тогтолцоог сайжруулах, эдийн засаг дээр төрийн оролцоог эрс хязгаарлах, чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Одоо 30 жил явсан. Үзсэн, харсан, туршсан.

Тэгэхээр бид эдийн засгийн либерал бодлогыг явуулах ёстой гэж үздэг. Би иймбайр суурьтай хүн байгаа юм.

Н.Учрал: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Өнөөдөр шинээр томилогдож байгаа М.Бадамсүрэн гишүүнд баяр хүргэе.

Орон нутагт аймгийн засаг даргаар ажиллаж байсан. Хөдөөгийн амьдралыг мэдэх ийм хүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар томилогдож байгаа явдалд нь баяртай байна.

Энэ орон нутгийн амьдрал, малчдынхаа асуудлуудыг, тариаланчдын асуудлуудыг ойлгодог яаманд томилогдох нь зарчмын хувьд их зөв зүйл болж байна гэж бодогдож байна. Нэг асуулт байгаа юм.

Ж.Энхбаяр сайдын хувьд Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар жил гаруй ажиллалаа. Анх удаа Хүнс, хөдөө аж ахуйн яамыг орон нутаг руу шилжүүлсэн. Ер нь бидний хувьд харахад төдийлөн үр дүнгээ харж чадалгүйгээр дараагийн албан тушаал руу томилогдов уу гэж бодогдож байна.

- ▷ **Нэгдүгээрт**, М.Бадамсүрэн сайд Хөдөө аж ахуйн яам орон нутагт байгаа, тэнд байрлаж ажиллаж байгааг юу гэж үзэж байгаа вэ? Буцаагаад Улаанбаатар хот руу шилжүүлэх үү? Тэнд нь үргэлжлүүлээд явуулах уу? Яагаад гэдэг асуултад хариулж өгөөч ээ гэж хүсэх байна.
- ▷ **Хоёрдугаарт**, Ерөнхий сайдаас бас нэг асуулт асуумаар байна. Энэ удаагийн Засгийн газар, ялангуяа Г.Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газар хууль зөрчсөн үйлдэлтэй тэмцэх, хулгай дээрэмтэй хэзээ ч нийлэхгүй, шударга ёсыг эрхэмлэнэ гэдэг зарчим барьж ажиллаж байгаа. Өөрөө ч ингэж илэрхийлж байгаа.

Аймгийн Засаг даргууд дээр асуудлууд байна. Хууль зөрчиж томилогдсон асуудал байна. Засаг даргаар томилогдсоноосоо хойш хууль зөрчөөд ажиллаад байгаа тухай, хууль бус шийдвэрүүд гаргаад байгаа тухай хэд хэдэн асуудлууд сонсогдож байна.

Зарим нэг нь хууль хяналтын байгууллагуудаар шалгагдаад явж байгаа юм байна. Жишээ нь, Булган аймгийн Засаг дарга хууль зөрчиж томилогдоод өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа. Тэр нь Үндсэн хуулийн цэц дээр очоод маргаан үүсгээд шалгагдаж байгаа гэдэг асуудлууд яригдаж байна.

Тэгэхээр энэ асуудлуудтай Та хэрхэн яаж ажиллах вэ? Ингээд үргэлжлүүлээд явах уу? Эсвэл өөрчлөөд, одоо ярьж байгаа шигээ зарчмаа бариад явах уу гэдэг асуулт асууя.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулъя. Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Ер нь хууль тэгш үйлчлэх ёстой. Тийм учраас аймгийн Засаг дарга нар, аливаа албан тушаалтнууд хууль зөрчсөн нь тогтоогдох юм бол хариуцлага тооцоод явна. Булган аймгийн Засаг даргын асуудал цэц дээр асуудал нь хууль бусаар томилогдсон байдаг юм бол тэр асуудал нь цэц дээд шийдвэрүүдээ гаргавал тэрийг дагаж мөрдөөд л асуудлуудыг хуулийн дагуу шийдэж байгаа.

Ер нь зөвхөн аймгийн Засаг дарга нарт төдийгүй нийт төрийн албан хаагчид төрийн өмчит компаниудад ч гэсэн ийм зарчмын шаардлага тавиад Засгийн газраас хяналт шалгалтын ажлыг явуулж байгаа. Зарим улсын үйлдвэрийн газрууд, төрийн өмчит компаниуд, агентлагууд дээр тодорхой хууль зөрчсөн байж болзошгүй үйлдлүүд гарсныг шалгаж байгаа. Ингэж хөрөнгө мөнгө шамшигдуулсан, хууль зөрчсөн үйлдлүүд гарвал тухай бүрд нь хариуцлага тооцож ажиллах болно.

Н.Учрал: Нэр дэвшигч М.Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Шинэ Засгийн газар байгуулагдаад 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө батлуулахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг харьяа байгууллагын яамд Дархан аймаг руу нүүлгэн шилжүүлнэ гэж Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахад батлагдсан.

Энэ дагуу Засгийн газар 2024 оны 32 дугаар тэмдэглэлээр чиглэл өгөөд Дархан-Уул аймаг руу тодорхой хувь нь нүүн шилжиж, тэнд үйл ажиллагаа явуулж байгаа юм билээ.

Ер нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр “Хот, хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд яамны харьяа байгууллагууд, ер нь төрийн байгууллагуудын 10 хувийг орон нутагт шилжүүлнэ гэдэг ерөнхий бодлого энэ үйл ажиллагааны хөтөлбөр... /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут.

М.Бадамсүрэн: Үйл ажиллагааны зорилтод батлагдсан байдаг.

Тэгээд Ерөнхий сайд томилсны дараа энэ нөхцөл байдалтай танилцана. Ажилтан албан хаагчтай уулзалт зохион байгуулна.

Ер нь бодлогын залгамж чанар үргэлжилж явах нь зөв. Гэхдээ энд ажиллаж байгаа албан хаагчдын нөхцөл байдлыг судална. Байр орон сууц, нөхцөл, ирж очиж зорчиход ямар асуудал тулгамддаг вэ. Одоо явж байгаа үйл ажиллагаа нь ямар байна гээд.

Ер нь үйлдвэрлэл хариуцсан, хувийн хэвшил хариуцсан байгууллагууд нь Дархан-Уул аймагт үйл ажиллагаагаа голлон явуулж байгаа гэж миний хувьд эхний байдлаар мэдээлэл авсан. Тэгээд эргэж дараагийн чуулганы хуралдаан дээр бас энэ талаар, эсвэл танд тусгайлан ямар санал байгаа талаараа танилцуулъя.

Тэгээд шийдвэрийг Засгийн газар, Улсын Их Хурал гаргана гэж ойлгох хэрэгтэй.

Н.Учрал: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Өдрийн мэнд.

Нэг сайдын ёндоотой хэдэн хүн байна. Ж.Энхбаяр сайд чинь гурав дахь удаагаа сайд хийж байна. Одоо бодвол Монголын шилдэг боловсон хүчин юм байлгүй гэж эрх барьж байгаа нам нь үзэж байгаа байх.

Тэгээд сая хэлж байна. Өөрийнхөө тойрог руугаа яам аваад явчихсан. Одоо М.Бадамсүрэн сайд нь Улаанбаатар хот руу авчрах тухай ярьж байна. Арай ч Дорнод руугаа аваад явчихгүй байлгүй.

1990 оноос хойш ер нь 36 жилийн 30-д нь та нар засагласан. 2016 оноос тасралтгүй 10 дахь жилдээ жилдээ засаглаж байна.

Энэ хугацаанд 4 Засгийн газар дамжаад 115 хүн давхардсан тоогоор сайд хийсэн. М.Бадамсүрэн сайд 116 дахь сайд. Дэд сайд нарыг оруулах юм бол энэ тоо 250 давна. Давхардсан тоогоор сайд болж байгаа хүмүүс бүгдээрээ танай намын гишүүд буюу танай намын Удирдах зөвлөлийн гишүүн, Их Хурлын гишүүн.

Тэгээд энэ хугацаанд энэ 116 хүн асуудлыг шийдсэн нэг ч салбар байхгүй.

- ➔ “Өвдөх л юм бол үх” гэдэг эрүүл мэндийн салбартай.
- ➔ Тэтгэвэртээ гарах бол яаж ийж байгаад “2 жил хүлээгээрэй” гэдэг нийгмийн хамгааллын салбартай.

Гараад Улаанбаатар хотоо хар. Төлөвлөлтгүй, төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүй, замбараагүй хотыг Та нар бий болгосон.

- ▶ “Утаа” та нарын уран бүтээл.
- ▶ “Түмнээ ядуурлаас гаргана” гэсэн. Гаргаагүй. Улам ядуурсан. Өөрсдөө л баяжсан.

Тэгээд бүгдээрээ ээлжилж солигдоод л сайд хийгээд байдаг. 200 хүний дотор бүх юм нь эргээд байдаг. Ийм байж болохгүй л дээ.

Холливудын “Оушены арван гурван” /Ocean’s Thirteen/ гээд кино байдаг. Та нар үзсэн байх. Тэр кинон дээр 100 сая доллар дээрэмдэх гээд 13-нд цуглаж байгаад тэр хотыг дэлбэлдэг байхгүй юу.

- ▶ Та нар яадаг гэхээр “Ногоон автобус” оруулж ирээд 100 сая доллар авчихдаг. Бүр төгсөрчихсөн.
- ▶ Сайхан нэртэй, гоё зорилготой бүх сангуудыг тонон дээрэмдсэн.
- ▶ Жижиг, дунд үйлдвэрлэлийн санг бүгдээрээ хувааж байгаад тэнцүү авсан. Нэг хүний 950.0 сая төгрөг. Өвсний толгой тэнцүү тайрч байгаа юм шиг.
- ▶ Боловсролын зээлийн санг бүгдээрээ авсан. Хүүхдүүдтэйгээ хамт авсан. Онц сурдаг, хичээж мэрийгдэг энгийн амьдралтай айлын хүүхдийн боломжийг урдуур нь орж хуу хамсан.

Тэгээд одоо дахиад засаглаж байгаа. Ер нь 3 сонгууль дараалаад ялахаар одоо ёстой надад хэн хэлэх вэ дээ гэдэг л байдалтай ханддаг юм шиг байна. Үүнийг манай иргэд харж л байгаа байлгүй дээ.

Өнөөдөр асуудал нь шийдэгдсэн салбар энэ улсад нэг ч алга.

Монгол Улсад мөнгө байна уу. Байна. Маш их мөнгө байна. Зөвхөн 2026 оны төсөв чинь ороод 100 их наяд хүрч байгаа. Сүүлийн гуравхан жил. Ийм их мөнгийг зүгээр гарын салаагаар урсгасан. Асуудлаа шийдэж чадаагүй. Өнөөдрийг болтол.

Ийм харгис хандлагаа, ийм хүйтэн сэтгэлээ хэзээ болих юм.

Асуулт асуухаар гоё тойруулж хариулсан болоод л. Бид асуусан болоод л. Та нар хариулсан болоод л дуусдаг. Ийм нөхцөл байдлаа өөрчлөгдмөөр байна.

Талбайгаа тойроод биш талбайгаас хойш 5 километрийн радиуст яваад үз. Би өчигдөр Ерөнхий сайд руу Та энэ сайд нараа хороо, эмнэлэг дээр очиж үзүүлээч гэдэг мессеж бичсэн юм. Арай дэндүү харгис бодлого, арай дэндүү хүйтэн сэтгэл гаргаж байна.

Тэгээд л 115 хүн ээлжлээд сайд болоод байдаг. Энэ чинь 2016 оноос давхардсан тоогоор 115 сайд хийж байна шүү дээ. М.Бадамсүрэн сайдыг шинэ юм даа гэж оруулбал 116 дахь нь.

Албан тушаалын төлөө болохоор хоорондоо үзээд байдаг. Ажил хийх болохоор байхгүй.

Н.Учрал: Үг хэллээ. Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ерөнхий сайдын томилгоог хүндэтгэж байна. Улс төрийн нөхцөл байдлыг нь ч гэсэн ойлгож байна. Дэмжиж байна. Улсын Их Хурлын гишүүн болохын тулд бас нэг тодорхой хэмжээний амлалт өгөөд ажил хийгээд туршлага хуримтлуулсан хүмүүсийг сайдаар ийш тийш нь сэлгэж байгаа байх.

Гэхдээ өмнө нь үг хэлсэн хүмүүс нэлээн давхардаад хэллээ.

Асман лам шиг хэдэн сайдтай болсон. 90 оноос хойш л улс төрд гарч ирсэн. Одоо болтол буудаггүй. Үг хэллээ гээд гомдоод гоншигноод байхгүй байлгүй дээ, Ж.Энхбаяр сайд.

Ер нь хөдөө аж ахуйн салбарт нэг тийм гарт харагдаж, нүдэнд баригдахуйц ажил гараагүй. Сүүг нь ууж байна. Махыг нь идэж байна. Энэ учраас л малчид хөдөө байна. Бусдаар хөдөө байх ямар ч бодлого, хөшүүрэг тэнд байхгүй.

Дархан руу нүүж байгаа Хөдөө аж ахуйн яам хэдэн газар тариалан байна. Түүнийг нь тойрч байгаа хэдэн махны үхэр, сүүний үнээ л байна. Үүнийгээ л хөдөө аж ахуй гээд ойлгож байх шиг байна.

Уулын мухарт яг чин сэтгэлээсээ малаа маллаад, таван хошуу малаа эрс тэрс уур амьсгалтай дөрвөн улиралд нь зохицож маллаад Монгол Улсын хөдөө аж ахуйн бодлогыг бодоод явж байгаа малчдад хэрэгтэй. Арьс шир нь, өл нь, дайвар бүтээгдэхүүн нь үнэд ордог юм одоогоор Монголд нэг ч байхгүй. Үүний төлөө хэн ч ажиллаагүй.

М.Бадамсүрэн сайд Дорнодын хөрсөнд нэлээн сайн боловсрогдсон, хөдөө аж ахуйн салбарыг нэлээн гадарлах хүн томилогдож байгаа учраас бас нэг хонгилын үзүүрт гэрэл харагдах байх гэж итгэж байна даа.

Уг нь хоёр сайд томилогдож байгаа юм чинь минутаа хоёроор үржүүлээд авчхаж болохгүй юу. Хоёуланд нь хандаж үг хэлэх гэхээр энэ минут багадаад байх юм.

Ж.Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн сайд болж байгаа. Мэргэжлийн бус. Тэгээд би үгнийхээ эхэнд хэлсэн. Ерөнхий сайдын зовлонг ойлгож байна. Энэ салбарт сая манай намын З.Нарантуяа захирал нэлээн бодлогын бичиг баримтуудын төслийг бэлдсэн гэж ойлгосон. Энэ дээр нь Та дэмжихийг нь дэмжээд, мэргэжлийн хүмүүсийг томилоод, Хөгжлийн банкныг ажилд нь оруулаасай гэж Танаас хүсэж байгаа юм.

Улсын Их Хурлаар сайд нарыг бол дүүрч. Ерөнхий сайдын бүрэн эрх учраас ойлгоод, дэмжээд явуулъя.

Тэгтэл мэргэжлийн бус хүмүүс Улсын Их Хурлаас томилогдоно гээд дараа дараагийн бялуугаа хүлээгээд сууж байгаа нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх боломжгүй шүү гэдгээ энд давхар хэлье.

Сая Ерөнхий сайд хэлээд байна. Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулахдаа. Хууль зөрчөөд байгаа Засаг дарга нарт хуулийн хариуцлага хүлээлгэнэ л гэж байна.

► Баянхонгор аймгийн Засаг дарга хууль зөрчөөд Төрийн албаны зөвлөлийн хууль зөрчиж 7 томилгоо хийсэн. 7 томилгоо нь буцсан боловч Засаг дарга хариуцлага хүлээгээгүй.

► Өвөрхангай аймгийн Засаг дарга мөн адил. Одоо Баянхонгор сумын иргэдийн Хурал хуралдаад байхад сумын Засаг даргыг Ардчилсан намд өгч чадахгүй одоо болтол новшроод сууж байна.

Би Ардын намын дарга хийж байгаа залууг нь ч танина. Ардчилсан намын дарга болох гэж байгаа залууг нь ч танина.

Адилхан залуучууд дэмжээд ажлыг нь хийлгээд, одоо энэ өвөл хүндэрч байна, асуудал ихсэж байна, утааны нөхцөл байдал зөвхөн Улаанбаатарт биш үргэлжлүүлээд аймгуудад байгаа. Эдгээр асуудлууд дээр Ерөнхий сайд болон танхимын сайд нар нь анхаарлаа хандуулаад ажилдаа шуурхай ороорой гэж хүсье. Баярлалаа. Үг хэллээ.

Н.Учрал: Да.Цогтбаатар гишүүн үг хэллээ. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Ерөнхий сайдаас тодорхой хоёр юм асууна.

Хэрэв би андуураагүй бол Б.Энхбаяр сайдыг томилохоор мэдэгдэл хийж байхдаа хулгайтай тэмцэнэ. Өмнөх сайд маань ерөөсөө тэмцэж өгөхгүй байна.

Тийм учраас хулгайтай тэмцье, яаравчилъя, хурдалъя, одоо томиллоо гээд томилж байсан юм.

- ➔ Хулгайтай тэмцэх ажил маань юу болсон? Б.Энхбаяр сайд Та хоёрын.
- ➔ Явц нь ямар болж байна?

Б.Энхбаяр сайд бараг цусны шинжилгээнээс бусдыг нь гаргаад тавьсан. Илрэх нь үү? Энэ хэрэг. Нүүрсний хулгай яриад байна л даа. Би мартчихсан уу.

- ▷ **Нэгдүгээрт**, бүх баримтыг нь гаргаад тавьчихсан. Цаг нартай, нэртэй устай. Одоо намын дарга Их Хурлын дарга хийж байгаа. Нам дээр жишээлбэл хариуцлага яригдах уу? Баримтууд нь ил байгаа. Цусны шинжилгээнээс бусад нь.
- ▷ **Хоёрдугаарт**, томилгоо яригдаж байгаа дээр л би Ерөнхий сайдаас асуумаар байгаа юм. Та санал нэг байгаагаа удаа дараа хэлж байгаа зүйл нь юу вэ гэхээр төр бол хэт данхайсан. Төр хэт их данхайсан. Ингэснээрээ төрийн зардал нэмэгдсэн. Авлига, хулгай гарсан гэдэгтэй Та санал нэг байгаагаа удаа дараа хэлж байгаа.

Одоо өөрөө энэ төрийн данх бүтцээ хэзээ өөрчлөх вэ? Яаж өөрчлөх вэ? Энэ саналаа оруулж ирэх үү? Энэ таны онцгой бүрэн эрх. Ерөнхий сайдын. Их Хурлын гишүүн бол Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай хууль санаачлах эрх байхгүй.

Хэрвээ Та оруулж ирэхгүй бол иргэдээ би бас уриалмаар байгаа юм. Одоо таны санаачилсан “d-petition” дээр өргөдөл гаргаж болно. Засгийн газрынхаа бүтэц, бүрэлдэхүүнийг багасга, дарга нарынхаа тоог.

Нэг бол дарга, нэг бол ядуус гэдэг л боллоо. Монгол Улс.

Тэгэхээр дарга нарынхаа тоог цөөл гэдэг өргөдөл иргэд нь санаачлах ёстой юу? Та эсвэл өргөн барих ёстой юу? Ийм маш тодорхой хоёр асуулт Танаас асууя.

Ж.Энхбаяр сайдаас ч одоо асуух асуулт алга. Хэлэх үг ч алга. Түрүүн манайхан хэлж байна.

- Батлан хамгаалахын сайд байсан.
- Хүнс, хөдөө аж ахуйн сайд байсан.
- Одоо Эдийн засаг, хөгжлийн сайд болж байна.

Тэгээд ийм супер хүнээс асуух асуулт алга. Хэлэх үг алга.

Сүүлийн 1 минутад би шинээр томилогдсон Их Хурлын даргад залуу хүний хувьд тодорхой саналуудыг хэлэх гэсэн юм. Гуравхан санал хэлье.

Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа танай намын хурлын үйл ажиллагаанаас доор боллоо.

- ➔ **Нэгдүгээрт**, Даргын дэргэдэх зөвлөл гээд нэг chat байна. Viber. Уг нь тав дахь өдөр хуралдаад хэлэлцэх асуудлаа баталдаг юм.

Тэгээд тэр батлагдаад л Даваа гарагаас эхлээд л тэр chat дээр пижигнэсээр байгаад нөгөө хэлэлцэж баталсан бүх асуудлууд нь алга болдог.

Одоо энэ чуулганы нэгдсэн хуралдаан жишээлбэл тэр chat-ын үр дүн. Энэ даргын дэргэдэх зөвлөлийг хуралддаг байлгая. Ингээд chat-лаад л “өө тэлье, тэлье” гээд асуудлыг өөрчилдөг. Хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилдөг. Энэ байдлыг халж өгөөч гэж.

- ➔ **Хоёрдугаарт**, санал хураасны дараа горимын санал гаргадаг. Асуудал унахаар гишүүд худлаа ярьдаг. Төхөөрөмж ажилласангүй гэж. Ийм шалтгаанаар горимын саналаар хураах хууль байхгүй.

Тэгэхээр Та битгий ийм горимын саналаар санал хураалгаарай.

- ➔ **Гуравдугаарт**, санал хураалтыг ирэх долоо хоног болгож хойшлуулъя гэдэг. Гишүүдийг жоохон хариуцлагатай байлгах асуудлыг өнгөрсөн хугацаанд байхгүй болгосон. /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох асуудлыг танилцуулж байгаа.

Энэ асуудалтай холбогдуулж асуулт хариулт явж байна гэж ойлгож байгаа. Төсвийн хэлэлцүүлгийн үед энэ асуултуудаа асууж ярилцах байж.

Бид үндсэн чиглэл, төсөв хэлэлцэх үеэр төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгож, Засгийн газар байгуулагдаад долоо ч хоноогүй байхдаа төсвийн тодотголыг өргөн барьж, төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгож, 2.2 их наяд төгрөгөөр данхайсан гээд байгаа төсвийн орон тоо, зардлыг танасан.

Энэ хүрээнд 6 мянган дарга цэрэг, ажлын байруудыг цомхотгож нэлээн одоо олон агентлаг, зөвлөл, үндэсний хороодыг татан буулгаж багасгасан.

Гэвч Улсын Их Хурал дээр төсөв хэлэлцэх үед төрийн албан хаагчдын орон тоо гэхэд цомхотголоо. Андуураагүй бол Та ч гэсэн төрийн албанд ер нь тодорхой асуудлуудыг шийдэхэд тодорхой саналууд гаргаж байсан. Төсвийг Та танилцуулж байсан.

Энэ ажил үргэлжлээд явж байгаа. Төрийн өмчийн компаниудын түвшинд ч явж байна. Үр ашиггүй зардлыг танах ажил явж байна. Сая төсвөөр ч гэсэн бид бас ахиад 1 их наядаар таналаа.

Ер нь Монгол Улсын бүх төсвийн түүхэнд төсөв дандаа тэлж байсан болохоос биш төсвийн зардлыг танасан, орон тоог багасгасан шийдвэр ганц ч гаргаж байгаагүй юм билээ. Манай Засгийн газар түүхэндээ анх удаа 2.2 их наядаар төсөв танаж данхайсан бүтцийн орон тоо, зардлыг хэмнэсэн бодлого хэрэгжүүлсэн.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоогүй ч гэсэн ер нь бас энэ хүрээнд харин төсөвт өөрчлөлт хийж байна гээд нэг тогтсон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх өөрөө асар их зардалтай байдаг.

Яам, Тамгын газар машин унаатай ноцолдсон үр дүнгүүд эсрэгээрээ ихээхэн зардал гаргадгийг Та сайн мэдэж байгаа. Яам нийлүүлээ гэхэд тамга тэмдэг, цаас хэвлэл, албан бланкаас авхуулаад л тэгээд ширээ сандал, бүх юм бужигнуулаад л, дагаад л төрийн албыг бужигнуулаад л, орон тоо нэг бөөн юм болж байдаг.

Тийм учраас мөрийн хөтөлбөрөө тогтвортой хэрэгжүүлэхийн тулд өмнөх Засгийн газрын бүтэц үндсэндээ хэвээрээ ажиллаж байгаа. Түүнээс биш тэр үндэсний хороод шат шатдаа орон тоо цомхотгосон талаар тодорхой мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд тодорхой тоо баримтаар танилцуулсан байгаа.

Энэ жилийн төсөв батлагдахад ч гэсэн бас 1 их наядаар төсөв урсгал зардлыг танаж, багш, эмч нарын цалинг нэмсэн. Тодорхой хэмжээний зайлшгүй хөрөнгө оруулалт... /минут дуусав/

Н.Учрал: Ч.Лодойсамбуу гишүүн асуулт асуулаа.

Тэгэхээр даргын дэргэдэх зөвлөлийг биеэр хуралдуулаг байхад анхаарна. Гэхдээ энэ бол ирцийн байдлаас шалтгаалаад байгаа юм байна. Бас нэн яаралтай горимоор Засгийн газраас хууль өргөн мэдүүлэх, Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх асуудал гээд хурдан хугацаанд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг даргын зөвлөлөөр оруулж хэлэлцэх асуудал дээр нэмэхийг цахимаар шийдээд явдаг юм байна. Ийм жишиг.

Цаашид биеэр хуралдаж шийддэг байх буюу ер нь өнгөрсөн долоо хоногийн тав дахид хэлэлцэх асуудлаа баталсан бол дараалал өөрчлөгдөхгүй байхад анхааръя.

Гэхдээ нэгэнт дэгийнхээ хууль дээр нэн яаралтай горимоор хууль оруулахыг нь зөвшөөрсөн хуулийн зохицуулалттай учир бид тэр хуулиа л барьж ажиллана. Санал хураасны дараа горим гаргах асуудал дээр гишүүд өөрсдөө анхааралтай байх ёстой.

Тэгэхээр бэлтгэл ажлаа хангуулах, бүртгэлийн ирцүүдийг авч ер нь бэлтгэл ажлыг сайтар хангаж байя.

Магадгүй ирэх долоо хоног руу шийдээд байхаас илүүтэйгээр тав дахийн өглөө ч юм уу, нэгдсэн санал хураалтуудыг нэгдсэн байдлаар зохион байгуулах гээд ер нь дэгийн хуулиа бүгдээрээ ажлын хэсэг гаргаад дахиад ярих нь зөв юм шиг байна шүү. Тэгэхгүй бол дэгийн хууль дээр М.Бадамсүрэн гишүүний нэг хууль яваад байна. Дэгийн хуулийг гишүүд тал талаас нь яриад байвал цаашид яг нэг мөр хэрэглэхэд бас асуудал үүсгэнэ.

Тийм учраас ер нь дэгийн хууль дээрээ нэг ажлын хэсэг байгуулаад, Их Хурлын хоёр дэд даргаар ахлуулаад нэг ажиллаж үзэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хуулийн заалтууд байгаад байгаа учраас хуулиа мөрдөөд явахаас өөр арга зам алга гэдгийг хэлье.

Ч.Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал даргад баярлалаа.

Тэгээд залуу хүн учраас залуу хүний зарчим үзүүлж ажиллана гэдэгт итгэж байгаа.

Ерөнхий сайдаас би хоёр асуулт асуусан. Хоёулаа хэлэлцэх асуудал, сайд нарын томилгоотойгоо хамаагүй ч гэсэн гэж байгаад нэгэнд нь хариулаад нэгийг нь орхичихлоо.

Хулгайтай тэмцэх ажил маань юу болж байгаа вэ? Та хоёрын гээд байгаа шүү дээ. Үүнийг нэг тодорхой хариулаад өгөөч. Больсон юм уу, яасныг л мэдмээр байна л даа.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Хулгайтай тэмцэх ажил үргэлжилж байгаа. Хууль хяналтын байгууллагууд ажлаа хийж байгаа.

Ер нь энэ талаар тодорхой асуудлуудыг хууль хяналтын байгууллагуудаас очоод асуух эрх нь Улсын Их Хурлын гишүүдэд бүрэн нээлттэй байгаа. Мөрдөн шалгах байцаах ажиллагааны нууцтай хавтаст хэрэгтэй бид танилцаад нээгээд хаагаад байдаг улсууд биш. Тэгэхдээ бүх шатад хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгөгдөөд ажлын хэсгүүд байгуулагдаад явж байгаа.

Жишээлбэл, энэ хүрээнд олон 10 сая доллар хилээр гаргадаг байсныг зогсоолоо. Олон тэрбумын алт хилээр гарч ирснийг Та бүхэн харсан байх. Барьж авлаа. Энэ бол хулгайтай тэмцэж байгаа ажлуудын бодитой үр дүнгүүд. Энэ хүрээнд тодорхой мөрдөн шалгах байцаах ажиллагаанууд бүх шатад явж байгаа. Харин энэ ажлыг Улсын Их Хурлын гишүүд маань цаашдаа улс төрийн дэмжлэг үзүүлж дэмжинэ гэдэгт итгэж байна.

Тодорхой хэрэг үйл явдлын талаар Ерөнхий сайд ярих эрхгүй.

Н.Учрал: Ч.Лодойсамбуу гишүүн асуулт асууж байна. Ерөнхий сайд хариуллаа.

Миний хувьд ч гэсэн Их Хурлын даргын хувиар, эрх барьж байгаа намын даргын хувиар байр сууриа илэрхийлсэн. Засгийн газрын авлигатай тэмцэж байгаа бодлого, үйл ажиллагааг бүрэн дэмжиж ажиллана. Энэ танхимаас хулгайч төрдөг биш хууль төрдөг байх ёстой. Энэ танхимаас ёс зүй эхэлдэг байх ёстой.

Тийм учраас үнэхээр зарим шаардлагатай мэдээллүүдийг Ерөнхий сайд Их Хуралд хүсэлт тавивал хаалттай хэлбэрээр хуралдаад нөхцөл байдлын үр дүнгүүдийн талаар хаалттай мэдээлэл хийх нь зөв байх гэж бодож байна.

Ингээд Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Оройн мэнд.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайдаар ажиллаж байсан Ж.Энхбаяр сайд маань Эдийн засаг, хөгжлийн яамны сайдад нэр дэвшиж байгаа юм байна.

Анх Дархан руу нүүлгэхдээ ерөөсөө л Дарханд л байж байж энэ салбар маань хөгжих юм. Тэр л хамгийн зөв бодлого юм гээд маш олон гишүүд асууж байхад өөрөө итгэл төгс хариулж байсан. Тэгтэл одоо шинэ сайд нь үүнийг Улаанбаатар луу буцаад нүүлгэнэ гэж байгаа. Ингэж ийм тоглоомтойгоор засаг барьж болж байгаа юм уу гэдгийг нэгд асуумаар байгаа юм. Өмнөх олон гишүүд ч үүнийг асууж байна.

Тэгээд Ж.Энхбаяр сайдын намтраас харахад Та нефть, онцгой албан татварын гаалийн газрын дарга, Улаанбаатар хотын гаалийн газар, Гаалийн ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газар гээд ер нь манай Монгол Улсад ажиллаж байгаа бизнес эрхлэгч нарт хамгийн их хүнд суртал гаргадаг, авлига, хээл хахуулиараа алдартай газруудад ажиллаж байсан туршлагатай хүн юм байна.

Таны хувьд энэ байгууллагуудын үйл ажиллагааг ер нь юу гэж хардаг вэ? Өөрийнхөө ажиллаж байсан жилүүдийн туршлагаас харахад. Энэ байгууллагуудын үйл ажиллагааг нь ер нь яаж сайжруулж байж эдийн засагт үзүүлж байгаа, бизнес эрхлэгч нарыг хохироогоод хаагаад боогоод байгаа энэ байдлыг өөрчлөх вэ гэж Та харж байна.

Тэгэхээр Та ажиллаж байх хугацаандаа ямар дүгнэлт хийсэн. Одоо Эдийн засаг, хөгжлийн яамны сайд болоод гаальтай холбоотой байнга үүсэж байдаг, мэргэжлийн хяналтын байгууллага байхгүй ч гэсэн яамдаас байдаг бүх хяналттай холбоотой асуудлууд дээр ер нь ямар бодлого баримтлах вэ гэдгийг асууя.

Хоёр дахь асуулт, Эдийн засаг, хөгжлийн сайдын хувьд Та –

- эрчим хүчний салбарт ямар бодлого баримтлах вэ?
- нэг худалдан авагчийн загварыг нь төрөөс хэт хамааралтай энэ загвараар Та явуулахыг дэмжих үү?

2024-2028 онд эрчим хүчний либералчлал хийнэ гэж нэрлээд нэг лоозон болгож хаясан байгаа. Эрчим хүчний зах зээлийг чөлөөлөөд өрсөлдөөнт зах зээл оруулна гэсэн. Өнөөдрийн байдлаар тэр огт хэрэгжихгүй байгаа.

Таны хувь хүний бодлого ямар байдаг вэ? Дээрээс нь хувь хүний хувьд Та эрчим хүчний салбарт улсын төсвийн хэдэн хувь ногдох хэрэгтэй гэж хардаг вэ?

Сүүлийн асуулт. “Монгол Улсын бүтээмжийн тухай” асуулт.

Та бодитоор хөдөлмөрөөр баталгаажуулах мөнгөний нийлүүлэлтээс болж инфляц өөрөө өдөөгдөөд байгаа. Он гараад инфляц улам нэмэгдэнэ. Өнөөдрийн

Статистикийн хорооноос гаргаж байгаа инфляцын түвшнийг Та бодит гэж бодож байна уу? Монгол Улс ер нь инфляцаа бодитоор тооцож чадаж байна уу? Та энэ дээр ямар бодлоготой байгаа вэ?

Н.Учрал: Жадамбаагийн Энхбаяр нэр дэвшигч.

Ж.Энхбаяр: Дархантай холбоотой.

Ер нь Монгол Улсын бүс болон орон нутгийн хөгжлийн ялгааг арилгах асуудал энэ парламентын гол зорилт.

Хүн амын дийлэнх нь бага хэмжээний газар төвлөрч суугаад байгаа байдал улс орны аюулгүй байдал, ер нь хөгжлийн бодлогод маш сөрөг нөлөөллийг үзүүлж байгаа.

Хөдөө хөгжүүлж байж, хөдөөд хүн ажиллах, амьдрах, орлоготой байх орчныг бүрдүүлж байж улс орны хөгжлийн бодлого хангагдана гэж үздэг хүн. Ийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар ажлын байран дээрээ яг үйлдвэрлэл явуулж байгаа тэр орон зайд очих нь зүйтэй гэж үзсэн. Үүний үр дүн ч гарч байгаа. Түгжрэлгүй, асуудлыг багцаар нь, уялдаа холбоотой нь, төрийн албан хаагчид нэг доор нэг байшинд суугаад үйлдвэр эрхлэгчидтэйгээ хамтраад ажиллавал үр дүн гардгийг сая өнгөрсөн хугацаанд харуулж байгаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөлтийн 60 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хангадаг болж байна. 48 мянган ажлын байрыг шинээр бий болголоо. Бодлогын хэд хэдэн томоохон арга хэмжээ, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ. Эерэг үр дүнгүүд гарч байгаа.

Хөдөөгийн хөгжлөө бид хангаж байж бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах л бидний зорилт. Энд чухал байх болов уу гэж бодож тэр санаачилгыг гаргаж, Та бүгд Улсын Их Хуралд дэмжиж тогтоол гаргаж энэ салбарыг Дархан-Уул аймагт шилжүүлсэн.

Би гаргасан шийдвэртээ зөв гэдэгт одоо ч итгэл төгс байгаа. Цаашдаа ч ийм байх ёстой. Хөдөөгийн хөгжлийг хангах, бүс нутгийн хөгжлийн ялгааг арилгах нь Монгол Улсын гол зорилго. Үүнийг хийхэд төрийн захиргааны байгууллагуудыг шилжүүлэх, нүүлгэх, их дээд сургуулиудыг төвлөрлөөс гаргах зайлшгүй хэрэгтэй. Энэ бодлогыг харин бодлогодоо тууштай авах хэрэгтэй.

Эхний зам гарлаа. 20 гаруй жил ярьцгаасан юм. Үр дүн болдог юм байна. Зөвхөн хүнс, хөдөө аж ахуй Дарханд очсонтой холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын гол бизнес, бэлтгэн нийлүүлэлт бүгд дагаад гарлаа шүү дээ.

Өнөөдөр Та бүхэн Дархан-Уул аймгийн хөгжлийн төлөв байдалтай танилцаж болно. Дархан-Уул аймаг 1 их наядын эдийн засгийг үйлдвэрлэдэг хот болж хувирч байна. Асар их хөрөнгө оруулалтыг татаж байна. Хүн ам мянга

мянгаараа шилжин суурьшиж байгаа. Ийм л бүс нутаг болж хувирч байна шүү дээ.

Тэгэхээр энэ бодлогуудыг ганц Хүнс, хөдөө аж ахуйн яам биш олон яамдыг, тусгай чиг үүргийн байгууллагуудыг ер нь Улаанбаатар хотоос гаргах нь чухал. Аюулгүй байдлын үүднээс ч их хэцүү байгаа. Ковид цар тахлын том сургамж байна. Хүнсний хангамжийн асуудал байна. Бохирдлын асуудлууд байна гээд. Төвлөрлийг задалж байж л бид шийднэ дээ.

Түүнээс эндээ л асуудал овоолоод энэ дотроо л байгаад байна гэвэл улам л бид хүнд байдал руу орох болов уу гэсэн бодолтой байна. Энэ үүднээс хийгдсэн ажил юм шүү гэдгийг ойлгохыг хүсэж байна. Цаг нь дууслаа.

Гааль, мэргэжлийн хяналтын газруудад би 8 жил гаруй ажилласан. Өргөсөн тангарагтаа үнэнч, нэр төртэй төрийн албыг амжилттай гүйцэтгэсэн.

Н.Учрал: С.Цэнгүүн гишүүн тодруулна.

С.Цэнгүүн: Тэгээд сая Ж.Энхбаяр сайдын ярианаас сонсоход Дархан руу нүүлгэх нь зөв байсан юм байна.

Тэгэхээр Ерөнхий сайд Г.Занданшатар бас энэ дээр адилхан бодлоготой байгаа юу? Ер нь кабинетын зарчмаараа Та бүхэн ч адилхан бодлоготой болоод орж ирж байгаа юм болов уу гэж харсан.

Тэгэхээр энэ талаараа М.Бадамсүрэн сайдтай ярьсан байгаа юу? Та.

Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамны сайд нь Дархандаа байсан нь зөв өө гэж үзэж байгаа юм бол тэгвэл М.Бадамсүрэн сайд томилогдоод ч гэсэн Дархандаа Хүнс, хөдөө аж ахуйн яамаа байлгах нь зөв юм биш үү? Г.Занданшатар Ерөнхий сайд энэ дээр тэгвэл юу гэж бодож байгаа юм?

Н.Учрал: Жадамбаагийн Энхбаяр гишүүн хариулна.

Ж.Энхбаяр: Газар нутгийн 1 хүрэхгүй хувь байгаа. 0.7 хувь нь газар тариалан буюу ургамал ургах, болц гүйцэх таатай орчинтой. Тэр нь энэ төвийн бүсдээ төвлөрч байгаа. Төвийн бүсийн хөдөө аж ахуйн салбарыг, төвийн бүс дэх аж үйлдвэрлэлийг бид өөрчилж байж Монгол Улсыг өөрчилнэ гэж би боддог.

Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, хүн амын дийлэнх, газар тариалангийн нутгийн бараг 90 гаруй хувь нь жижиг, дунд үйлдвэрлэлийн орчин, үйлдвэрлэлүүдийн 80-аас 100 хувь нь үндсэндээ төвийн бүсэд төвлөрч байгаа.

Дархан-Уул аймгийн асуудал биш шүү дээ. Төвийн бүсийн төв Дархан хот. Тэнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн бодлого амжилттай хэрэгжиж байж төвлөрлийг сааруулах Монгол Улсын бодлого, зорилт хэрэгжиж байна.

Ж.Энхбаяр гэдэг хүн санал гаргаад нүүсэн асуудал биш шүү дээ. Улсын Их Хурал тогтоол гаргаж нүү. Энэ төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүл гэдэг үүргийг Та бүгд санал хурааж, алга ташиж надаа үүрэг өгсөн. Би тэр үүрэг л биелүүлж байгаа хүн шүү дээ.

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: С.Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг Засгийн газар биелүүлэх үүрэгтэй. Хэлэлцэх эрх байхгүй.

Тийм учраас Улсын Их Хурал шийдвэр гараад хаашаа нүү гэнэ тийшээ л нүүнэ шүү дээ. Та хэд тогтоолоо өөрчлөх юм бол тэгээд буцаад ир гэвэл ирнэ. Төвлөрлийг сааруулах, Улаанбаатар хотын түгжрэлийг шийдэхийн тулд нүү гээд шийдсэн. Тийм.

Н.Учрал: Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн.

П.Мөнхтулга: Эдийн засаг, хөгжлийн сайд, Хөдөө аж ахуйн сайд хоёр шинээр томилогдож байна.

2023 оны 4 сард Францын хөдөө аж ахуйн сайд Монгол Улсад ирж айлчилсан. Дараа нь 6 сард Ерөнхийлөгч Э.Макрон ирж айлчилсан. Манай хөдөө аж ахуйн салбарыг маш ихээр онцолж байсан. Францын хөдөө аж ахуйн сайд хэлэхдээ Монгол Улсын хөдөө аж ахуйн сайд болохыг бүх дэлхийн хөдөө аж ахуйн сайд нар мөрөөддөг байх гэж хэлж байсан.

Тэгэхээр хөдөө аж ахуйн сайд бүх дэлхийн мөрөөдлийн албан тушаал дээр очиж байна. Аргагүй. Бидэнд бэлэн ийм сайхан соёл байгаа. 70 сая мал байгаа. 200 мянган өрх малчид байгаа.

Тэгэхдээ та энэ малчдыг малчид гэдэг хуучин 35 жил, социализмын үеийн 70 жилийн энэ өнцгөөр нь битгий хараарай. Шинэ сайд. Олон улсын бизнес эрхлэгч монгол махаар дэлхийг дайлах хүмүүс гэж хараарай. Одоо тэгээд шинээр томилогдож байгаа учраас шүүмжлэх ч юм алга. Ажлыг нь харъя.

Эдийн засаг, хөгжлийн сайдаас асуух асуулт байна. Бид сая төсвөө баталж байхад багш, эмч нарын цалин нэмэх мөнгө байхгүй. Хөрөнгө оруулалтад тавих мөнгө байхгүй гээд. Тэгэхдээ хайгаад ухаад хэрэггүй зардлуудаа хасаад эхлэхээр байдаг юм байна. Гараад ирсэн. Одоо харин төрийн өмчит компаниудаа цэгцэлж болохгүй юм уу? Төрийн өмчит компанийн орлого чинь уг нь төрийн

өмчит л компани юм чинь улсын төсөвт л ирж нэмэр болох ёстой шүү дээ. Хувь эзэмшигч, ногдол ашиг хүртэгч нь төр юм чинь, Монголын ард түмэн юм чинь.

Тэгтэл энэ компаниуд чинь худлаа тайлан гаргаад ашгаа нуугаад, эсвэл олсон ашгаараа өөрсдийгөө шагнах юм. Байраар шагнах юм. Цалингаа 100 саяын урамшуулал гээд өөр өөрсдийнхөө захирлууд нь чагнаад явчих юм.

Дээрээс нь нүүрс чинь өөрөө хөл ургаад гараад гүйхгүй шүү дээ. Энэ авто тээврийн газар энэ “Си” зөвшөөрөл өгч байгаа машинууд дээр авлигууд нөгөө оймс моймсондоо нуугаад л бөөн асуудал болж байсан. Энэ яасан? Одоо нүүрс дээр өртөг нэмж дундаас нь хусаж байгаа бүх хүмүүсийн л асуудал шүү дээ. Авто тээвэр.

Дээрээс нь Үндсэн хууль зөрчиж байгаа бас нэг асуудал байгаа. Бас яг авто тээвэр дээр. Үндсэн хуулийн 17.3 дээр монгол хүн өмчтэй байх эрхтэй, өмчөө захиран зарцуулах эрхтэй. Тэгтэл эвдэрхий машинтай бол тэр нь өмч биш. Бусдад зарж болохгүй. Заавал оношлуулаад ир гэдэг. Тэгээд нэг ийм оношилгооны мафи болсон. Монгол Улсын иргэн болгон машинаа зарахын тулд заавал нэг хүнээс зөвшөөрөл авдаг. Өмчөө захиран зарцуулахын тулд авто тээврийн газраас зөвшөөрөл авдаг. 3 дугуйтай байна уу, 2 дугуйтай байна уу, 4 дугуйтай байна уу тэр хүний л өмч. Эвдэрхийгээр нь зарна уу, оношлуулаад зарна уу энэ Үндсэн хуулийн асуудал.

Тэгэхээр энэ журмыг хүчингүй болгох ёстой.

Тэгээд дээрээс нь төрийн өмчит компаниуд дээр тэр нэг Мэдээлэл, харилцаа холбооны төрийн өмчит хувьцаат компани гэж байна. Шуурхай яаралтай онцгой нөхцөл байдалд ямар ч тийм нөхцөл байдал гараагүй байхад 5.3 тэрбум төгрөгөөр шууд гэрээгээр бензин худалдаж авсан байх юм. Тэр харилцаа холбоонд ёстой цахим байх ёстой, ложистик, ямар нэгэн тээвэр бензин хэмнэх ёстой газар чинь яагаад 5.3 тэрбум төгрөгөөр шууд худалдан авалтаар бензин аваад байдаг юм. Энэ дээр хариулт авъя.

Н.Учрал: Тэр төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль 5 дугаар сард Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Нийтийн өмчийн хуулийг бас Засгийн газар өргөн мэдүүлсэн. Тэгээд Их хурал дээр анхны хэлэлцүүлэг нь эхлэх ёстой. Хэлэлцэх эсэхийг нь хоёуланг нь дэмжсэн.

Ингээд анхны хэлэлцүүлэг хийгдэх гээд хүлээж байна. Тэгээд Их Хурал дээр энэ дарагдсан байгаад байна л даа. Тэгээд би өнөөдөр Их Хурлын даргын захирамжаар хоёр өмчийн хуулийн ажлын хэсгийг нь шинээр томилоод шахаж шаардаж ажиллая гэж бодож байна.

Энэ хууль гарахгүйгээр Засгийн газар энэ компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, нөгөө нээлттэй компани болгох асуудлыг шийдэж бүрэн чадахгүй. Их Хурлаас, Засгийн газраас төрийн өмчит компани дээр баримтлах чиглэлийг оруулж ирэх ёстой.

Тэгэхээр Ж.Энхбаяр томилогдож байгаа сайдад болоод Засгийн газраас төрийн өмчит компанид баримтлах чиглэлээ энэ хууль батлагдангуут оруулж ирээд, тэр нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, аль аль компанийг нээлттэй болгох гэж байгаа гэдэг асуудлаа Их Хурлын тогтоолоор шийдэж ав гэдэг чиглэлийг өгч байна.

Ж.Энхбаяр гишүүн. Сая П.Мөнхтулга гишүүний асуултад нэмж хариулна.

Ж.Энхбаяр: Төрийн өмчийн ашиглалт, үр ашгийг дээшлүүлэх нь энэ Засгийн газрын гол бодлого байгаа. Ерөнхий сайдын “Шинэ итгэл, эрс шинэтгэл”-ийн нэг том чиглэл бол яг энэ чиглэл. Иж бүрэн системийн шинжилгээ дүгнэлт хийгдээд үндсэндээ дуусаж байна.

Хууль эрх зүйн орчин Улсын Их Хуралд өргөн баригдаад хэлэлцүүлэх шатдаа явж байна.

Ер нь төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй гэдэг гол зарчмыг л яаралтай хэрэгжүүлэх. Эдийн засгийн эрх чөлөө, өмчийн эрх чөлөөг баталгаажуулах, хувийн хэвшилд гадаад зах зээлийг нээх, худалдаа тарифын аливаа тэр хорио цээр, босго, хязгаарлалтуудыг багасгах энэ бодлогыг л хэрэгжүүлнэ.

Чөлөөт худалдааны хэлэлцээрүүд энэ дотор орно.

Евразийн эдийн засгийн холбоотой хийсэн хэлэлцээрүүдийг одоо бид Улсын Их Хуралд өргөн барьж эцэслэн батлуулах ажил байна. Солонгостой хийж байгаа чөлөөт худалдааны хэлэлцээрийн асуудлууд байна буюу зах зээлийг л тэлэх, экспортыг л дэмжих, үйлдвэрлэлийг дэмжих.

Түрүүн хөдөө аж ахуйн салбарын асуудал дээр яригдлаа. Мал, махны үнэ өсөөд байгаа. Гол зарчим суурь нь ерөөсөө л экспортыг дэмжсэн. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 3 жил бид 300.0 сая доллар хүрсэн экспортыг мах, махан бүтээгдэхүүн дээр жил дараалан хийж байна. Яг одоогийн байдлаар 270, 280 сая долларын экспорт гарчхаад байна. 300 хүрэх байх. Үүнийг дагаад малчдын орлого, мал аж ахуй эрхлэх сонирхол бий болж байгаа.

Үйлдвэрлэл мөн адил. Үйлдвэрлэл буюу нэмүү өртөг бүтээж байгаад бүх чиглэлээ л бид дэмжиж урамшуулах хэрэгтэй. Зөвхөн ноолуурын салбар түүхий гаргадаг ноолуураа дотооддоо 100 хувь боловсруулаад угаадаг самнадаг болсноор 700.0 тэрбум буюу 200.0 сая долларын нэмүү өртөг Монгол Улсад үлдэж байна шүү дээ.

Ажлын байрыг бий болгож байна, татварыг бий болж байна, ашиг болж байна, үйлдвэрлэлийн өргөтгөл болж байна.

Тэгэхээр экспорт нөгөө талдаа үйлдвэрлэл гэсэн энэ бодлогыг л бид бүх талаар дэмжиж явуулах ёстой болох байх. Ингэхийн тулд бидний хамгийн анхаарал татаж байгаа хувийн хэвшил төр хоёрын өрсөлдөөн. Төрийн өмчит компаниудын хувийн хэвшил дэх оролцоо. Энэ зааг ялгааг маш тодорхой болгох. Үндсэндээ замын дүрмийг тодорхой болгоё. Энэ нэгдүгээр эгнээний зам, хоёрдугаар зам, ногоон гэрэл, байгууламж, явган зам гэдэгтэй адилхан бизнесийн дотоод, ялангуяа төрийн өмчийн компаниудын ч эрх, үүрэг чигийг гүйцэтгэх ажлыг тодорхой болгож, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй, хувийн хэвшлийн салбарт орохгүй байхыг тодорхой болгох бодлого хэрэгжүүлэх ёстой гэж бодож байна.

Н.Учрал: Ж.Энхбаяр гишүүн асуултад хариуллаа. Ерөнхий сайд нэмж хариулна.

Г.Занданшатар: П.Мөнхтулга гишүүний төрийн өмчит компаниудын захирлуудтай холбоотой асуудлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт хэрэгжүүлэх газар Тэргүүн Шадар сайдын харьяа хяналт шалгалтын ажил явуулж байгаа.

Хянан шалгаад тодруулаад танд эргэж хариу өгье. Хэрвээ хууль зөрчсөн таны хэлж байгаа тэр олон тэрбумын бензиний асуудал, аливаа асуудал хууль зөрчсөн, үр ашиггүй ажилласан асуудлууд байх юм бол хариуцлага тооцож ажиллана.

Н.Учрал: Тэр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчим сая батлагдсан төсвийн хүрээгээр тодорхой болсон. Тэнцвэржүүлсэн орлого, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 37 хувь байсан. 30.9 рүү буулгасан.

Тэгэхээр Ж.Энхбаяр гишүүн сайдаар томилогдоод төсвийн хүрээ, макро хэдэн тоонуудаа хатуу барьж байхгүй бол олон сайд нарын ятгалгад орж орлогыг буруу төлөвлөдөг, макро тоонуудыгаа хөдөлгөдөг, хувийн хэвшлийн орон зайг янз бүрийн байдлаар хязгаарласан тийм бодлого шийдвэр гаргахгүй байна байх гэж итгэж байна.

Энэ харьцааг хадгалж байж цаашаа хувийн хэвшил энэ орон зайд бизнесийн үйл ажиллагаа явуулна.

О.Амгаланбаатар гишүүн.

О.Амгаланбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ард түмэндээ яаж эргэж ирэх вэ гэхээр ард түмний итгэл чинь эргэн тойронд чинь байгаа авлигалчдаас чинь болоод байхгүй болсон шүү дээ. Н.Учрал дарга аа. Та тэр Ням-Осор гуайн Их засаг гээд Их хааны хуулиар, үзэл санаагаар

бас хүмүүжсэн залуу гэж харж байна. Одоо ард талд чинь “Алд бие минь алжаабал алжаатугай, ахуй төр минь бүү алжаатугай” гээд байж байна.

Тэгэхээр Үндсэн хууль зөрчсөн, Үндсэн хуулийг таны наад суудал дээр чинь сууж байгаад цагаан дээр хараар бичсэнийг зөрчсөн Үндсэн хууль зөрчигчөөсөө эхлээд ард түмэнд ирэх юмаа бас хийх хэрэгтэй гэж хэлэх байна. Үндсэн хууль зөрчигчдөдөө хариуцлага тооцохгүй эвлэрээд явах юм бол ард түмний итгэл улам холдоно.

Дээр нь Улсын Их Хурлын танхим дотор Үндсэн хуулиа зөрчөөд байх юм бол үүнээс хойш Монгол Улсад хууль хэрэгжихгүй гэдгийг хэлье.

Сая бүгдээрээ л ам амандаа шударга ёс гэдэг юмыг ярьж байна. Өө ёстой бүгд л сайхан шударга ёс. Шударга ёс гэдэг юмыг чинь амаараа биш ажлаараа харуулах ёстой.

Сая асуусан бүх хүмүүс, хариулж байгаа сайд нар хэлж байна. Гэтэл энэ танхимд чинь байгаа хүмүүст бас л энэ нүүрсний хулгайчид байна. Энэ хүмүүстэйгээ хариуцлагаа хамгийн түрүүнд тооцно гэдэгт найдаж байна гэдгийг хэлье.

Дээр нь манай гишүүд хэлж байх шиг байна. Төрийн өмчит компаниуд дээр чинь дүүрэн хулгай байна. Хэрвээ төрийн өмчит компаниуд дээр байгаа хулгайтайгаа тэмцэж чадахгүй бол энэ төр цаашаа яаж явах юм бэ? Төрийн өмчөөс чинь яаж хулгай хийдэг вэ гэхээр тэр төрийн өмчит компанийн чинь алдагдалтай ажиллуулж хулгай хийж байна.

Саяхан хэдхэн жилийн өмнө С.Бямбацогт Зам, тээврийн сайд байхдаа бүх аймаг руу онгоц нисгээд л. МИАТ гэж компани гайгүй ашигтай ажиллаад л. Жилд нэлээн ашигтай ажиллаж байна даа гээд л явж байсан чинь одоо яг өнөөдрийн байдлаар 2025 оны 9 сарын байдлаар 6 тэрбум төгрөгийн алдагдалтай. Оны эцэс болоход бараг 10 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байна шүү дээ. Бүх төрийн өмчит компаниуд чинь ийм байдалтай байж байх жишээний.

Цахилгаан холбоо гээд компани байна. Н.Учрал Их Хурлын даргыг сайд байхад нь аудитаас энэ хүн төрийн мөнгөөр архи худалдаж авсан байна гэдэг аудитын дүгнэлт нь хүртэл ирсэн байна шүү дээ.

Тийм хүмүүстэй хариуцлага тооцож чадахгүй бол энэ төр гэж байж яах юм бэ? Одоо энд байж байгаа нүүрсчдийн чинь цаана байгаа тэр цүнх баригчидтай хариуцлага тооцож чадахгүй бол, зарчим гэдэг зүйлийг ярихгүй бол хүмүүс ээ, энэ төрд итгэх итгэл чинь улам холдлоо.

Яг энэ чигээрээ байх юм бол хэдэн цүнх баригчид болсон нүүрсчид нь баяжаад ард түмэн нөгөө танай Д.Сарангэрэлийн хэлдгээр улам доошоо баларлаа шүү дээ.

Тэгээд өнөөдөр М.Бадамсүрэнгийн томилгоон дээр их сайхан байна.

Г.Занданшатар дарга өнөөдөр нэг баяны хүүхдийг ч гэдэг юм уу, амьдрал мэдэхгүй тийм цагаан гартныг биш аймгийн даргыг 3 удаа хийгээд, хар бор ажил, халуунд нь халж, хүйтэнд нь хөрч байсан аймгийн даргын томилгоо оруулж ирж байгаа нь маш сайн байна.

М.Бадамсүрэн чи аймгийн дарга нарын нэрийг хөөдөхгүй, аймгийн дарга нар ийм байдаг юм гэтэл нь ажиллаарай. Чи баруун аймгуудаар нэн яаралтай яваарай. Зөвхөн зүүн аймгууд биш баруун аймгуудын аймаг болгоны зовлон өөр учраас чи тэрийг яагаад. Чи тэгээд аймгийн дарга нарын нэрийг нэг ингэдэг юм даа гэдгийг харуулна гэдэгт найдаж байна. Минутаа бас авчихъя. Цааш нь.

Н.Учрал: О.Амгаланбаатар гишүүн 1 минут.

О.Амгаланбаатар: Ж.Энхбаяр сайдад хэлэхэд Ж.Энхбаяр сайд бас олон жил төрийн алба хашлаа. Говь-Алтайгаас Их Хурлын гишүүн байсан хүн.

Тэгэхээр та одоо энэ бүсүүдийг, ялангуяа баруун бүсийн ард иргэд төвийн бүсийн ард иргэдээс хоёр дахин бага орлоготой. Дээр нь дахиад хоёр дахин бага орлоготойгоос гадна хоёр дахин илүү өртгөөр амьдарч байна.

Тийм учраас баруун бүсийн ард иргэдийн тал дээр амьдралын чанарыг сайжруулах, дэд бүтцийн хөгжил гэх талаас нь сайн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна шүү. Та энэ талын арвин их туршлагатай хүн учраас энэ дээр сайн анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Тэгээд манай Говь-Алтайд “малын эзэн”, “үйлдвэрийн эзэн” гэдэг зүйлийг танай яаман дээр, одоо очиж байгаа яаман дээр чинь нэг тендер зарлагдаад шалгарсан байгаа. Тэр ажлыг сайн хийх юм бол Монголын хөдөө аж ахуйг өөрчлөх, хот хөдөөгийн ялгааг арилгах, малын гаралтай түүхий эдийг боловсруулах дээр эргэлт гарна шүү гэдгийг хэлье.

Н.Учрал: О.Амгаланбаатар гишүүнд баярлалаа.

Төрийн өмчийн компанийнхаа хуулийг парламент яаралтай баталж өгмөөр байна. Их Хурал дээр хэт их удсан. Түүнээс болоод Засгийн газар баримтлах чиглэлээ оруулж ирэх гэхээр, статусыг нь тодорхой болгох гэхээр тийм эрх зүйн боломж байхгүй байна шүү дээ. Одоогийн хуулиар.

Тийм учраас нийтийн өмчийн хууль, төрийн өмчийн компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг парламент яаралтай батлаад,

тэгээд Засгийн газраас төрийн өмчит компани дээр баримтлах чиглэлээ оруулж ирээд ингээд нэг талд нь гаргаад хурдан шийдээд явмаар байна.

Аль 5 сард барьсан хууль шүү дээ. Тэгээд одоо Их Хурал дээр анхны хэлэлцүүлэг нь огт хийгдээгүй. Тийм. 1 сард эхнийх барьсан. Тэгээд одоо түүнээс хойш энэ чинь бараг бүтэн жил болох гэж байна шүү дээ. Тэгээд сүүлд Б.Энхбаяр гишүүнээр ажлын хэсгийг ахлуулсан. Тэгээд Засгийн газрын гишүүнээр томилогдсон.

Тэгэхээр одоо Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгийг нь шинээр байгуулаад. Одоо энэ төрийн өмчит компанийн хууль болоод засаглалын шинэчлэлийн асуудал Их Хурлын ажил болсон шүү.

Тэгэхээр Их Хурлын гишүүд үүнд бүгдээрээ тал бүрээс идэвхтэй оролцоод, энэ хуулийг гаргаад, араас нь Засгийн газрыг шахаж шаардъя. Тэгэхгүй бол төрийн өмчит компанийг бүтэн жил ярилаа. Тэгээд цаашаа нэг талд нь гаргаж шийдэхгүй бол хүлээгдэж байна. О.Амгаланбаатар гишүүний хэлээд байгаа үнэн. Алдагдал нь ашиг болсон энэ хэдэн компаниудаа шийдэж авахгүй бол хувийн хэвшилд ч орон зай байхгүй боллоо.

Ингээд Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

Р.Эрдэнэбүрэн: Оройн мэнд хүргэе.

Өнөөдөр энэ томилгоо хийгдээд Засгийн газар цаашдаа бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаад явах ийм боломж бүрдэж байх шиг байна. Тэгээд хурдан ажилдаа орох байх гэж найдаж байна.

Тэгээд Ерөнхий сайдад хоёр санал хэлэх гэсэн юм. Яг өнөө маргаашгүй маш чухал хоёр асуудлыг шийдээд өгөх хэрэгтэй байна.

▷ **Нэгдүгээрт**, энэ жил бид урдаас нүүрс оруулж ирж түлж байгаа. Тэгээд маш олон хүн айдастай, эргэлзэж тээнэгэлзэж байна. Энэ нүүрс ер нь болж байна уу, болохгүй байна уу? Олон хүмүүс толгой түрүү эргэлээ, бие хөдөө аж ахуй өвдлөө гэж байна.

Тэгэхээр энэ эргэлзээг тайлсан, энэ нүүрсээ түлээд цаашаа явж болно, болохгүй гэснийг нэг тодорхой хариу хэлсэн, хариуцлагатай мэдэгдлүүдийг хийж өгмөөр байна. Болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу?

▷ **Хоёрдугаарт нь**, ханиад хүндрэлтэй, вирустэй маш хүнд байдалд ороод байна. Та бас эмнэлгээр дээр нэлээн явж байх шиг байна.

Одоо хэд хоногтоо ковидын үе шиг тодорхой цаг хугацаанд эмнэлгүүдийн нөхцөл байдлуудыг мэдээлж баймаар байна. Ор хаана боломжтой байгаа юм, эмч хаана үзэх боломжтой байгаа юм.

Тэгэхгүй бол хүүхдүүдээ аваад, халуурсан хүүхдүүдээ тэврээд эмнэлэг хэсээд ор олдохгүй яваад байна.

Тэгэхээр өдөр болгон мэдээллээ заагаад, тийшээ оч, ийшээ оч гээд хэлээд өгөхгүй бол маш хүндэл хүнд байдалтай байна. Тэгээд мэдээж өөрөө бас яваад байх шиг байна. Ж.Чинбүрэн сайд өдөр болгон гарч ирээд хэлээд баймаар байх юм. Тэгээд нэг хурал хийсэн. Боловсролын яам руу нэг бичиг бичсэн сурагтай. Нэг тийм хурал хийгээд л өнгөрөх шиг боллоо.

Тэгэхээр үүнийгээ жоохон тодорхой хэд хоногтоо болгож өгөх шаардлагатай байна.

▷ **Гуравдугаарт, Ж.Энхбаяр** сайд эдийн засгийг либералчилна, бизнес дэх төрийн оролцоог багасгана гээд чихэнд чимэгтэй маш сайхан зүйл ярьж байгаа.

Тэгээд үүнийг маш хурдан хийх байх гэж найдаж байгаа. Бодитой үйлдлүүдийг хийх байх гэж бодож байгаа. Хөрөнгө оруулалт “0” байгаа. Хөрөнгө оруулалтын хууль дахь бидний хүрч чаддаггүй хэд хэдэн асуудлууд байгаа. Үүнийгээ хурдан шийдэх хэрэгтэй байна.

Хөрөнгө оруулалт төслүүдийг хөдөлгөхөд саад болдог гадна, дотнын зохион байгуулалттай янз бүрийн эсэргүүцдэг хүмүүстэй ажиллаж тэр хөрөнгө оруулагч нартаа харуулах хэрэгтэй байна.

Төвийн бүсэд, ялангуяа Дарханд Хөдөө аж ахуйн яамыг аваачаад төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр сайн ажилласан гэж ингэж бодож байгаа.

Дарханд та одоо ингээд хөрөнгө оруулалт 1 их наяд хүрч байгаа гэж байна. Одоо тань дээр таны багцад энэ ТЭЗҮ, зураг төсөв хийдэг энэ бүх зүйл байж байгаа. Говийн бүсийн гол мөнгө олж байгаа бүсийнхээ дэд бүтэц, эрчим хүч, зам энэ тэрийг нь анхаарч өгмөөр байна.

Махны чиглэлээр Дорнодын нисэх онгоцны буудлыг янзалмаар байна. Чойрын 18-ын хуучин нисэх онгоцны буудлыг, Өмнөговийн нисэх онгоцны буудлыг хурдан янзалмаар байна.

Тэгээд нөгөө нарийн төмөр замыг. Хилийн бүс дэх. Үүнийгээ оруулж ирэхийг хурдан шийдэж шийдээд өгмөөр байна. Зоригтойнхон шиг хос төмөр замтай болох юм руу яваад өгмөөр байна.

Тэгээд ийм зүйлүүд дээр анхаарч өгөх байх. Төвийн бүс дээр харьцангуй нөхцөл байдал дэд бүтцийн хувьд сайжирсан. Говийн бүс жоохон хүнд байгаад

байгаа. Тэгээд өөрсдөө гайгүй мөнгөтэй учраа олчхож байгаа гэж бодоод яваад байдаг юм шиг байгаа юм.

Дэд бүтэц байхгүй бол нөгөө олборлож байгаа уул уурхайгаа бид... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Р.Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь өнгөрсөн хагас сайн өдрөөс эхлээд бид Эх нялхас, эмэгтэйчүүдийн Эрүүл мэндийн төв-2, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд ажилласан.

3-аас 4 цаг очерлож байгаа. Ханиад, томууны дэгдэлтийн нэмэгдсэн. Н3N2 гэдэг шинэ төрлийн мутацид орсон ханиадны төрөл их өндөр халуурал өгдөг, бас эрсдэлтэй нийгмийн шинж чанартай өвчин байгаа учраас яаралтай штаб байгуулж ханиад томуу, дэгдэлтийн эсрэг байгуулж ажиллаж байгаа. Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгааллын яамыг уялдаа холбоотой ажиллуулсан ийм урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн төвөөр бас урьдчилан сэргийлэх мэдээллийг бүх телевизүүдээр бас явуулж байгаа. Яаж урьдчилан сэргийлэх вэ, хамгаалах вэ. Бүх сургуулиудад урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэм тогтоож, маск зүүх, урьдчилан сэргийлэх хичээл хааж завсарлуулахаасаа илүү эхний ээлжид халдвар хамгааллын дэглэмээ сайжруулах чиглэл өгч ер нь бүх эмнэлгүүд дээр нэмэлт амбулатори, үзлэгийн өрөө гаргах, ор дэлгэх ийм ажил зохион байгуулж, 1320 ор өнөөдрийн байдлаар шинээр дэлгэх ажил явагдаж байна.

Нөөцөөс 1 тэрбум төгрөг гаргаж ханиад томууны эсрэг дайчлагдан илүү цагаар ажиллаж байгаа эмч нарт урамшуулал олгох шийдвэрийг гаргаад эмч нарынхаа урамшууллыг нь шийдээд ажиллаж байна. Ингээд богино хугацаанд ханиад томууны огцом дэгдэлт, халдварлалтыг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Ингээд 12 сарын 01-нээс цахимаар шилжүүлэх.

Ер нь 0-оос 5 насны хүүхэд 40 хувь нь, 5-аас 15 насны хүүхэд хооронд 40 хувь. 80 хувь нь үндсэндээ хүүхдүүдэд халдварлаад байгаа. Вакцинжуулалт эергээр нөлөөлж байгаа.

Ийм учраас ер нь өглөө бүр сургуулиуд дээр эрүүл мэндийн үзлэгийг сургуулийн эмч нар сургууль, цэцэрлэгт нэвтрүүлэх, иргэдэд өгөх, урьдчилан сэргийлэх мэдээллийг хэвлэлээр нэг мөр ойлгомжтой өдөр бүр хүргэж байх, дүүрэг бүр өрхийн эмнэлгүүдийг дайчилж ажиллаж байна. Бүх Нийслэлийн онцгой байдлын газар болон нийслэлийн эрүүл мэндийн төвөөс зохион байгуулаад бүх дүүргийн хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нар, нийгмийн ажилтан, хүүхдийн байцаагч, хуучнаар хүүхдийн асуудал хариуцсан ажилтнуудыг зорилтот бүлгийн хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ

явуулж байна. Зарим газрууд аав, ээж нь ажилдаа явдаг, аль эсвэл гадуур дотуур ой гаруйтай хүүхдүүдээ орхиж яваад бас хөлдөх эрсдэлд учирсан хүртэл илрүүлж хүүхдийг нь аварсан. Бас эцэг, эхийн анхаарал халамж сул байгаа энэ газруудад хэсгийн ахлагч, хүүхдийн байцаагч нарыг ажиллуулах гэх мэтээр урьдчилан сэргийлэх ажлыг нийслэлийн дүүрэг, хороо хэсэг болгон зохион байгуулж байна.

Ингэж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нь өвчилсний дараа эмчлэхээс урьдчилан сэргийлэх нь илүү гэсэн ийм тактик зорилтыг барьж ажиллаж байна.

Ер нь судалгаа тооцооллоор 12 сарын 10-аар оргил үедээ хүрч... /минут дуусав/

Н.Учрал: Ерөнхий сайд хариуллаа.

Өнөөдөр Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох асуудлыг Ерөнхий сайд чуулганы хуралдаанд танилцуулж байна.

Ингээд Ж.Энхбаяр сайдад хэдэн саналыг хэлье.

Өнгөрсөн хугацаанд Г.Занданшатарын Ерөнхий сайдтай Засгийн газар энэ 100 гаруй хоногийн хугацаанд тодорхой макро тоонууд дээр дэвшил гаргаж ажилласан. Экспорт 1.8 дахин өссөн байна. Түүхэн дээд түвшинд нүүрсний экспорт нэмэгдсэн цаг хугацаа өнгөрсөн хугацаанд үргэлжилсэн. Валютын нөөц тогтвортой 5.8 тэрбум доллар хадгалагдаж байна.

Мөн өнгөрсөн хугацаанд хөгжлийн таван жилийн үндсэн чиглэлийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Ингээд энэ долоо хоногт хуулиараа батлагдаж байгаа.

Тэгэхээр таван жилийн үндсэн чиглэлээ батлуулаад таван жилийн чиглэлээ баримталж цаашдаа Их Хурал, Засгийн газар ажиллана. Салбар болгон энэ таван жилийн үндсэн чиглэлээ барьж ажиллана.

Өнгөрсөн хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Зөвшөөрөл, мэдэгдлийн хууль, Уур амьсгалын өөрчлөлтийн хууль гэсэн хуулиудыг Засгийн газар танилцуулсан. Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болсон байгаа.

Тийм учраас таныг ирэх долоо хоногоос эдгээр хуулиудыг Их Хуралд өргөн мэдүүлэхийг хүсэж байна. Ингээд Их Хурлын зүгээс Эдийн засгийн эрх чөлөөний анхдагч хууль, Хөрөнгө оруулалтын хууль, зөвшөөрөл мэдэгдлийн хуулиудыг батлах ажлыг шуурхайлна.

Мөн Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурагдсан. Энэ чөлөөт худалдааны хэлэлцээрийг Их Хурал руу илгээж, Их Хурлаар бид хэлэлцэх ёстой. Ингэж байж 5 улсын парламент энэ чөлөөт худалдааны хэлэлцээрийг

үргэлжлүүлж батална. Ингээд уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлийн бодлого, үйл ажиллагаанууд хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яамны суурин дээр байгуулагдсан яам учраас чадварлаг олон залуучууд ажилладаг. Намайг очиход Ардчилсан намын дарга Л.Гантөмөр сайдаар ажиллаж байсан. Гэхдээ чадварлаг олон залуучуудыг төр тогтвортой ажиллуулах бололцоогоор хангаж ажилласан юм билээ. Би ч гэсэн үүнийг хүндэтгэж чадварлаг олон залуучуудыг дэмжиж ажилласан. Цаашдаа ч гэсэн энэ яамны үндэс суурь болсон төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах дээр дэмжлэг үзүүлж, өнгөрсөн хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яамны үндэс суурийг тавьсан энэ багийнхныг тогтвортой ажиллуулахад дэмжлэг үзүүлж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Тэгээд Их Хурлын зүгээс Засгийн газраас боловсруулсан таван жилийн чиглэл, бусад хэлэлцээрүүд, боловсруулагдсан байгаа хуулиудыг батлан гаргахад Их Хурлын даргын хувиар бүрэн дэмжлэг үзүүлж ажиллана гэдгээ илэрхийлье.

Ингээд өнөөдөр чуулганы хуралдаанд Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцууллаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. /алх цохив/

Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох асуудлыг Ерөнхий сайд Их Хурлын хуралдаанд танилцууллаа. /алх цохив/

Дараагийн асуудалд орно.

Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө. Их Хурлын гишүүдийг танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна. Бэлтгэл ажлыг хангуулъя. 10 минут бэлтгэл ажлыг хангуулъя. Их Хурлын гишүүдийг танхимд ирэхийг урьж байна.

Гурав.Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагаа

Дараагийн асуудалд оръё. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна.

Индэрт урья.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн холбогдох заалтыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар, Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар томилон батламжиллаа.

Монгол Улсын Засгийн газар шинжлэх ухаанд суурилсан бодлого, яамд, агентлагуудын уялдаа, хариуцлагатай удирдлагад суурилан улс орны хөгжлийн зорилгоо нэгдсэн бодлогод зангидан хэрэгжүүлэх учиртай.

Энэ зорилгоор Улсын Их Хуралд “Шинэ итгэл-Эрс шинэтгэл” хэмээх Монгол Улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэлээ өргөн мэдүүлээд хэлэлцүүлж байна.

Энэ бодлого, чиглэлийг тууштай хэрэгжүүлэхэд мэдлэг, туршлага авьяас, чадвараа зориулна хэмээн үзэж улс төр, төрийн албанд 30 гаруй жил тууштай зүтгэж, Улсын Их Хурлын гишүүнээр 4 удаа сонгогдсон, салбарын сайдаар томилогдон ажиллаж байсан туршлагатай улс төрч Жадамбын Энхбаярыг Тэргүүн Шадар сайдаар.

Тулгамдсан асуудлуудыг бодитой цогцоор шийдэх чадвартай, манлайлал, хариуцлагатай хэмээн энэхүү өндөр хариуцлагатай албан тушаалд томилон батламжилж байна.

Монгол Улсын Засгийн газар хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал, хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуйн салбар, хөдөөгийн хөгжлийн бодитой шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, мал эмнэлэг, үржил, хорио цээрийн бодлогыг шинэчлэх, бэлчээрийн нөөцийг зөв зохистой ашиглах, бэлчээрийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх, таримал ургамал хамгааллын тогтолцоог сайжруулах, хот, хөдөөгийн хөгжлийг шинэ шатанд гаргах, цаг агаар, байгалийн эрсдэлийн үеийн хамгаалалтыг сайжруулах, малын гаралтай түүхий эдийг үнэ цэнд хүргэхэд хөнгөн үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрлэлийн технологийн паркуудыг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зэрэг стратегийн зорилтуудыг тавин ажиллаж байна.

Эдгээр зорилтуудыг нэгдсэн удирдлагаар хангах, салбарын шинэчлэлийг эрчимжүүлэх ажлыг Мягмарсүрэнгийн Бадамсүрэн сайд хариуцаж ажиллах болно.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нь төрийн албанд 18 жил ажилласан.

Инженер, төрийн удирдлагын менежерийн мэргэжилтэй, шударга, ажил хэрэгч, салбар хоорондын зохицуулалтыг үр дүнтэй удирдах чадвартай гэж үзэж энэхүү хариуцлагатай албанд томилон батламжилж байна.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, иргэдийн амьдралын чанар, улс орны хөгжлийн ирээдүйн төлөө чин шударгаар ажиллана гэж итгэж томилж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа. Захирамжийг уншиж танилцууллаа.

Н.Учрал: Ерөнхий сайдад баярлалаа.

Одоо Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг эхэлье.

Нэгдсэн хуралдааны танхимын голд Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх байрлалыг бэлдсэн байгаа тул Засгийн газрын гишүүд байрлал эзэлнэ үү.

Засгийн газрын гишүүд тангаргийг хамтаар өргөнө. Засгийн газрын гишүүд тангаргаа өргөнө үү хэмээн урьж байна.

Ж.Энхбаяр, М.Бадамсүрэн: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би.

Улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

Н.Учрал: Засгийн газрын гишүүн төрийн сүлдэнд мэхийн ёсолж хүндэтгэл үзүүлнэ.

Одоо Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу Засгийн газрын гишүүд төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагааг эхэлье.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсгээ зурж байна. /алга ташив/

Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Мягмарсүрэнгийн Бадамсүрэн таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна. /алга ташив/

Улсын Их Хуралд Засгийн газрын гишүүний тангараг өргөсөн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танд улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Ерөнхий сайдын өмнө биечлэн хариулцаж, тангарагтаа үнэнч чин шударгаар ажиллахыг хүсье.

Ажлын амжилт хүсье. /алга ташив/ /Танхимд Төрийн дуулал эгшиглэв/

Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөлөө.

Та бүхэнд баяр хүргэж ажлын амжилт хүсье.

Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснөө мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 17 цаг 55 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД